



АНС-Н ГАРЫН АВЛАГА 2021-22

Арлингтон, Виржиния
www.apsva.us

АНС-н 2021-22
Хуанлиг дотор
хуудаснаас харна уу

8-р сар		СУРГУУЛЬ НЭЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ	
30 Mon	К-12 Хичээлийн эхний өдөр	9-р сар	
31 Tue	Ясли ба Виржиниа Сургууль Өмнөх Санаачилга Хичээлийн эхний өдөр	9 Thu	Бага сургууль
9-р сар		14 Tue	Дунд сургууль
3 & 6 Fri & Mon	Баяр – Хөдөлмөрийн өдөр	22 Wed	Ахлах сургууль
7 Tue	Баяр – Рош Хашана	23 Thu	Н-В Woodlawn & Arlington Community Ахлах Сургууль
16 Thu	Баяр – Ёом Киппур	30 Thu	Карьер Төв/ Арлингтон Тех
29 Wed	Бага/Дунд/Ахлах Сургуулиуд эрт тарна (Сургууль дээрх ажилчдын сургалт)	10-р сар	
11 Mon	Хичээл орохгүй (Дүүрэг хамарсан ажилчдын сургалт)	14 Thu	Langston ACYX
21 Thu	Бага сургууль эрт тарна - Эцэг эхийн хуралтай тул		
22 Fri	Бага, дунд сургуулиуд хичээл орохгүй – Эцэг эхийн хурал		
27 Wed	Бага/Дунд/Ахлах Сургуулиуд эрт тарна (Сургууль дээрх ажилчдын сургалт)		
NOVEMBER			
1 Mon	1-р улирлын төгсгөл		
2 Tue	Хичээл орохгүй (Дүн гаргах өдөр)		
4 Thu	Баяр – Дивали		
11 Thu	Баяр – Цэргийн баяр		
24-26 Wed-Fri	Баяр – Талархлын баярын амралт		
DECEMBER			
8 Wed	Бага/Дунд/Ахлах Сургуулиуд эрт тарна (Дүүрэг хамарсан ажилчдын сургалт)		
20-31 Mon-Fri	Өвлийн амралт		
17 Mon	Баяр – Доктор Мартин Лютер Кинг, Жр. Өдөр		
28 Fri	2-р улирлын төгсгөл		
31 Mon	Хичээл орохгүй (Дүн гаргах өдөр)		
9 Wed	Бага/Дунд/Ахлах Сургуулиуд эрт тарна (Дүүрэг хамарсан ажилчдын сургалт)		
21 Mon	Баяр – Ерөнхийлөгчийн өдөр		
MARCH			
3 Thu	Бага сургууль эрт тарна - Эцэг эхийн хурал		
4 Fri	Бага, дунд сургуулиуд хичээл орохгүй – Эцэг эхийн хурал		
16 Wed	Бага/Дунд/Ахлах Сургуулиуд эрт тарна (Сургууль дээрх ажилчдын сургалт)		
APRIL			
8 Fri	3-р улирлын төгсгөл		
11-15 Mon-Fri	Хаврын амралт		
18 Mon	Хичээл орохгүй (Дүн гаргах өдөр)		
MAY			
3 Tue	Баяр – Эйд ал-Фитр		
30 Mon	Баяр – Дурсгалын өдөр		
8 Wed	Бага сургууль эрт тарна		
15 Wed	Ахлах сургуулийн сүүлийн өдөр – Эрт тарна, Бага сургууль эрт тарна		
16 Thu	Дунд сургуулийн сүүлийн өдөр – Эрт тарна		
17 Fri	Бага сургуулийн сүүлийн өдөр – Эрт тарна		
JULY			
4 Mon	Баяр – Тусгаар тогтнолын өдөр		
5 Tue	Зуны сургуулийн эхний өдөр		
29 Fri	Зуны сургуулийн сүүлийн өдөр (Бага)		
AUGUST			
5 Fri	Зуны сургуулийн сүүлийн өдөр (Дунд/Ахлах)		

Шашны тэмдэглэлт өдрүүд (Дээр заасан баярууд; заагаагүй бол хичээл хуваарийн дагуу орно):

9с 6 (нар жаргах)–7: Рош Хашана

11с 28 (нар жаргах)–Дес 6: Ханука

4с 2 (нар жаргах)–Май 2: Рамадан

4с 17: Улаан Өндөгний баяр

9с 15 (нар жаргах)–16: Ёом Киппур

12с 25: Зул сарын баяр

4с 15 (нар жаргах)–23: Алгасал

5с 3 (нар жаргах)–4: Эйд ал-Фитр

11с 4: Дивали

12с 26–1с 1: Кванзаа

4с 15: Сайн Баасан гараг

7с 9 (нар жаргах)–10: Эйд ал-Адха

АНС-н тухай	2
Суперинтендентийн ажлын хэсэг.....	2
Сургуулийн салбар нэгжийн алба & хаягууд.....	2
Сургууль ба Хөтөлбөрүүд.....	2
АНС-тай холбоо барих сувгууд.....	3
Сургуулийн цагийн хуваарь.....	4
Нөхөх өдрүүд.....	4
Арлингтон Сургуулийн Зөвлөл.....	4
АНС-н Журам, Бодлогууд	5
Эцэг эхийн хариуцлагын мэдэгдэл.....	5
Захиргааны хуваарилалт.....	5
Элсүүлэлт.....	6
Хичээл таслах.....	6
Бусдыг дээрэлхэх, дарамтлах.....	7
Өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө.....	7
Шашин шүтэх эрх чөлөө.....	8
Тоглоом шоглоом хийх.....	8
Багш нарын талаар мэдээлэл авах эцэг эхийн эрх.....	8
Шалгалтаас татгалзах талаар мэдээлэл авах эцэг эхийн эрх.....	8
Нээлтийн дасгал.....	9
Бэлгийн зохисгүй үйлдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь.....	9
Хориотой бодисууд.....	9
Сурагчийн Бэлгийн Дарамт, Бэлгийн гадуурхал – IX Зэрэг.....	10
Сурагчийг жендерийн тодорхойлолтоор гадуурхахгүй байх.....	10
Сургуулиас гарах (Сургуулиасаа дундаас нь гарах).....	10
АНС-н Сурагчийн Эрх үүрэг ба Ёс Зүйн Журам	10
Эцэг эхтэй уулзах.....	11
Чөлөөлөлт/Захиргааны арга хэмжээнээс өөр арга хэмжээ.....	11
Тээврийн хэрэгслээр зорчуулахгүй байх.....	11
Сурагчийг ангид суулгахгүй байх.....	12
“Хоёр дахь Боломж” Хөтөлбөр.....	12
Сургуулиас түр чөлөөлөх.....	12
Захиргааны арга хэмжээг давж заалдах.....	13
Сургуулиас хөөх.....	14
АНС-д суралцуулахаас татгалзах.....	15
Гомдол гаргах.....	15

АНС-Н ТУХАЙ

Арлингтон Нийтийн Сургуулиуд нь хичээл сурлагын амжилт, зарчимч байдлыг бий болгохыг зорьж ажилладаг олон янзын хүмүүсээс бүрдсэн сургуулийн хамт олон юм. Бид сурагчдын ар гэр, олон нийттэй хамтран сурагч бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн халамжтай, аюулгүй, эрүүл сурах орчинд хичээллэдэг.

СУПЕРИНТЕНДЕНТИЙН АЖЛЫН ХЭСЭГ

Доктор Франциско Дуран

Суперинтендент
superintendent@apsva.us
703-338-6010

Катерин Ашби

Суперинтендентийн туслах, Сургууль Олон Нийтийн Харилцаа
catherine.ashby@apsva.us
703-228-6003

Ким Грэйвс

Сургуулийн Дэмжлэгийн Дарга
kimberley.graves@apsva.us
703-228-6008

Аррон Грегори

Олон Янз Байдал, Тэгш байдлын Дарга
arron.gregory@apsva.us 703-228-6269

Бриджет Лофт

Сургалтын Ахлах Ажилтан
bridget.loft@apsva.us
703-228-6145

Доктор Жон Маяо

Үйл Ажиллагааны Ахлах Ажилтан
john.mayo@apsva.us
703-228-6007

Кристин Смит

Салбарын Зөвлөх
christine.smith@apsva.us

Брайн Стоктон

Ажилтнуудын Дарга
brian.stockton@apsva.us
703-228-2497

СУРГУУЛИЙН САЛБАР НЭГЖИЙН АЛБА & ХАЯГУУД

Syphax Боловсролын Төв
2110 Washington Boulevard, Arlington, VA 22204

Thurgood Marshall Барилга
2847 Wilson Boulevard, Arlington, VA 22201

Худалдааны Төв/Байгууламж & Үйл ажиллагаа
2770 South Taylor Street, Arlington, VA 22206

СУРГУУЛЬ БА ХӨТӨЛБӨРҮҮД

БАГА СУРГУУЛЬ (Цэцэрлэгийн өмнөх-5-р анги)

Abingdon
703-228-6650 • abingdon.apsva.us

Arlington Шинжлэх Ухаанд Чиглэсэн Сургууль
703-228-7670 • asfs.apsva.us

Arlington Уламжлалт Сургууль
703-228-6290 • ats.apsva.us

Ashlawn
703-228-5270 • ashlawn.apsva.us

Barcroft
703-228-5838 • barcroft.apsva.us

Barrett
703-228-6288 • barrett.apsva.us

Campbell
703-228-6770 • campbell.apsva.us

Cardinal
703-228-5280 • cardinal.apsva.us

Carlin Springs
703-228-6645 • carlinsprings.apsva.us

Claremont
703-228-2500 • claremont.apsva.us

Discovery
703-228-2685 • discovery.apsva.us

Dr. Charles R. Drew 703-228-
5825 • drew.apsva.us

Alice West Fleet 703-228-5820 •
fleet.apsva.us

Glebe
703-228-6280 • glebe.apsva.us

Hoffman-Boston
703-228-5845 • hoffmanboston.apsva.us

Innovation
702-228-2700 • innovation.apsva.us

Jamestown
703-228-5275 • jamestown.apsva.us

Escuela Key
703-228-4210 • key.apsva.us

Long Branch
703-228-4220 • longbranch.apsva.us

Montessori Арлингтоны Нийтийн Сургууль
703-228-8871 • montessori.apsva.us

Nottingham
703-228-5290 • nottingham.apsva.us

Oakridge
703-228-5840 • oakridge.apsva.us

Randolph
703-228-5830 • randolph.apsva.us

Taylor
703-228-6275 • taylor.apsva.us

Tuckahoe
703-228-5288 • tuckahoe.apsva.us

Дунд сургуулиуд (6-8-р анги)
Dorothy Hamm
703-228-2106 • dorothyhamm.apsva.us

Gunston
703-228-6900 • gunston.apsva.us

Jefferson
703-228-5900 • jefferson.apsva.us

Kenmore
703-228-6800 • kenmore.apsva.us

Swanson
703-228-5500 • swanson.apsva.us

Williamsburg
703-228-5450 • williamsburg.apsva.us

Ахлах Сургуулиуд (9-12-р анги)
Arlington Community Ахлах Сургууль
703-228-5350 • achs.apsva.us

Wakefield
703-228-6700 • wakefield.apsva.us

Washington-Liberty
703-228-6200 • wl.apsva.us

Yorktown
703-228-5400 • yorktown.apsva.us

Тусгай Хөтөлбөрүүд
H-B Woodlawn (6-12-р анги)
703-228-6363 • hbwoodlawn.apsva.us

Arlington Карьер Төв (9-12-р анги)
703-228-5800 • careercenter.apsva.us

Карьер, Техник, Насанд хүрэгчдийн Боловсрол
Syрhах Боловсролын Төв 703-228-7200 • apsva.us/ctae

Langston (Ахлах Сургуулийн Үргэлжлэл)
703-228-5295 • langston.apsva.us

Шинэ Чиглэл (9-12-р анги)
703-228-2117 • newdirections.apsva.us

Нэгтгэлийн станц
703-462-5184 • apsva.us/integration-station

REEP (Арлингтон Боловсрол & Хөдөлмөрийн Хөтөлбөр)
Syрhах Боловсролын Төвийн Насанд Хүрэгчдийн Англи
Хэлний сургалт 703-228-4200 • apsva.us/reep

Eunice Kennedy Shriver Хөтөлбөр (Тусгай Боловсрол, 6-12-р анги)
703-228-6440 • shriver.apsva.us

АНС-ТАЙ ХОЛБОО БАРИХ СУВГУУД

Арлингтон Нийтийн Сургуулиуд нь эцэг эх, олон нийттэй төрөл бүрийн аргаар холбоо барьдаг.

АНС-н School Talk (Сургуулийн Яриа) нь имэйл, дуут зурвас, текстээс бүрдсэн зурвасны систем юм. Бүртгэл хийх үед сурагчдын ар гэрийнхэнг School Talk-д автоматаар бүртгэдэг. АНС-н School Talk-г ашиглан сургууль хаах, саатах зэрэг мэдээ, үүссэн нөхцөл байдлаас гадна аль нэг сургуульд хамаарах мэдээг минут алдалгүй хүргэдэг.

АНС-н Вебсайт www.apsva.us дээр сурагчдын ар гэр, олон нийтэд төрөл бүрийн мэдээлэл хүргэнэ. Мэдээ, зарлал, хуанли, сайтны хайлт, сургуулиудын сайтруу нэвтрэх холбоос, эцэг эхийн портал, АНС-н нийтийн сүлжээний холбоосууд болон бусад хэрэгслүүдийг ашиглан АНС-н талаар мэдээлэл авах боломжтой юм.

Сургууль болгон нь тус тусын вебсайт, онлайн хуанлиттай. Сургуулиуд нь АНС-н School Talk-оор дамжуулан сурагчдын ар гэрийнхэнтэй холбоо барьдаг ба олонх нь РТА суваг, АНС-н Reachjar цахим мэдээллийн үйлчилгээгээр мэдээлэл хүргэдэг.

АНС болон түүний сургууль, хөтөлбөрүүд нь нийгмийн сүлжээг мөн ашиглаж сурагчдын ар гэрийнхэн, олон нийттэй харилцдаг. АНС-н Facebook хаяг facebook.com/ArlingtonPublicSchools, Twitter хаяг [@APSVirginia](https://twitter.com/APSVirginia), Vimeo хаяг [@AETVaps](https://vimeo.com/AETVaps), Instagram хаяг [@AETVaps](https://instagram.com/AETVaps), You Tube хаяг youtube.com/AETVaps.

Арлингтон Боловсролын Телевиз (AETV) нь Comcast-н 70-р суваг болон Verizon FiOS-н 41-р сувгаар гардаг. АНС-н Сургуулийн Зөвлөлийн хурлыг дээрх хоёр сувгаар нэвтрүүлдэг. Мөн AETV нь АНС-н Snapshot, АНС-н Green Scene, АНС-н Partners in Action болон #digitalAPS зэрэг нэвтрүүлгүүдийг хүргэдэг. AETV нь мөн АНС-н төрөл бүрийн урлаг болон боловсролын арга хэмжээнүүдийг олон нийтэд зарладаг билээ. AETV-н хөтөлбөр, нэвтрүүлгийн хуваарийн талаарх нэмэлт мэдээллийг apsva.us/aetv хаягнаас аваарай.

АНС-н Хэлний Үйлчилгээний Бүртгэлийн Төв (LSRC) нь сургуулийн бүртгэлийн үйл явцыг хөнгөвчлөн Англи хэлийг хоёрдогч хэлээр ярьдаг ар гэрийнхэнд хэлний дэмжлэг үзүүлдэг. Language Line (Хэлний Шугам) нь АНС, сурагчдын ар гэрийнхнийг холбох бүх сургууль, сургуулийн албууд дээр байдаг утсаар хэлмэрчлэх үйлчилгээ юм.

АНС-н мэдээ мэдээллийг төрөл бүрийн хэлбэрээр нийтэлж байна. Үүнд АНС-н Гарын авлага, Эцэг Эхчүүдэд Мэдээлэл өгөх ном, АНС Friday 5 болон QuickFacts зэрэг орно. Нэмэлт мэдээллийг apsva.us/publications хаягнаас аваарай.

СУРГУУЛИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

Арлингтоны сургуулиуд 6 өөр цагийн хуваариар ажилладаг. Ихэнхи сургуулиуд хичээлийн цагаас гадна сургуулийн өмнөх болон дараах арга хэмжээг явуулдаг. Эдгээр хөтөлбөрүүдийн талаар болон автобусаар ирж очих боломжтой эсэхийг сургуулиасаа лавлаарай.

БАГА СУРГУУЛЬ: Abingdon, Campbell, Carlin Springs

Бүтэн хуваарь	Эрт тарах
8:00 a.m. - 2:41 p.m.	8:00 a.m. - 12:26 p.m.

БАГА СУРГУУЛЬ: Arlington Уламжлалт Сургууль, Barrett, Long Branch, Randolph

Бүтэн хуваарь	Эрт тарах
8:25 a.m. - 3:06 p.m.	8:25 a.m. - 12:51 p.m.

БАГА СУРГУУЛЬ: Arlington Шинжлэх Ухаанд Чиглэсэн, Ashlawn, Barcroft, Cardinal, Claremont, Discovery, Drew, Glebe, Fleet, Hoffman-Boston, Innovation, Jamestown, Key, McKinley, Montessori, Nottingham, Oakridge, Taylor, Tuckahoe

Бүтэн хуваарь	Эрт тарах
9:00 a.m. - 3:41 p.m.	9:00 a.m. - 1:26 p.m.

ДУНД СУРГУУЛЬ: Dorothy Hamm, Gunston, Jefferson, Kenmore, Swanson, Williamsburg

Бүтэн хуваарь	Эрт тарах
7:50 a.m. - 2:24 p.m.	7:50 a.m. - 11:54 p.m.

АХЛАХ СУРГУУЛЬ: Wakefield, Washington-Liberty, Yorktown

Бүтэн хуваарь	Эрт тарах
8:19 a.m. - 3:01 p.m.	8:19 a.m. - 12:34 p.m.

Н-В WOODLAWN & SHRIVER ХӨТӨЛБӨРҮҮД

Бүтэн хуваарь	Эрт тарах
9:24 a.m. - 4:06 p.m.	9:24 a.m. - 1:30 p.m.

АРЛИНГТОН КАРЬЕР ТӨВ

Бүтэн хуваарь	Эрт тарах
8:00 a.m. - 3:10 p.m.	8:00 a.m. - 12:25 p.m.

ХИЧЭЭЛ НӨХӨХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021-22 хуанлид бага, дунд, ахлах ангианд зориулан хичээлийн 181 хоногийг оруулсан. Хэрэв цаг агаарын таагүй нөхцөл байдал, урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүссэн эсвэл мужаас хичээлийн цагийг хязгаарласнаас сурагчид сургуульдаа 180 хоног хичээллэх боломжгүй болвол нөхвөр хичээлүүдийн хуваарийг дараах байдлаар гаргана:

БАГА, ДУНД, АХЛАХ СУРГУУЛИУД

Алдагдсан эхний арван өдрийг нөхөх шаардлагагүй.

АРЛИНГТОН СУРГУУЛИЙН ЗӨВЛӨЛ

Арлингтон Сургуулийн Зөвлөл нь давхардсан байдлаар 4 жилийн хугацаанд алба хашдаг 5 гишүүдээс бүрддэг. Алба хаших хугацаа нь сонгуулийн дараах жилийн 1-р сарын 1-ээс эхэлнэ. Сонгуулийн үйл явцын талаар сонирхсон иргэд Сонгууль Өгөгчийн Бүртгэлийн Алба болон Арлингтон Дүүргийн Сонгуулийн Зөвлөлтэй 703-228-3456 утсаар холбогдох боломжтой.

СУРГУУЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Арлингтон Сургуулийн Зөвлөл нь 2110 Washington Blvd, Syphax Боловсролын Төвийн Зөвлөлийн Өрөөнд сар бүрийн эхний болон гуравдахь Пүрэв гарагт ихэвчлэн хуралддаг. Сургуулийн Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн хурлаас нэг долоо хоногийн өмнө бэлтгэдэг ба BoardDocs вебсайтын "хурал" (meetings) хэсгээс харах боломжтой.

Сургуулийн Зөвлөлийн хурлуудыг Comcast Cable-н 70-р суваг, Verizon FiOS-н 41-р суваг, АНС-н вебсайтаар шууд нэвтрүүлдэг ба Баасан гарагийн оройн 9 цаг, Даваа гарагийн оройн 7:30-аас дахин гаргадаг. Хурлын үеэр нэвтрүүлгийг АНС-н вебсайтаас (apsva.us/school-board-meetings/) шууд үзэж болно.

СУРГУУЛИЙН ЗӨВЛӨЛТЭЙ ХОЛБОО БАРИХ

Арлингтон Сургуулийн Зөвлөл нь 2110 Washington Blvd, Syphax Боловсролын Төвийн хоёрдугаар давхарт байрладаг. Албан ажлын цаг өглөөний 8-аас оройн 5 цаг. Иргэдийг Сургуулийн Зөвлөлийн гишүүдтэй уулзуулах нээлттэй цаг нь Даваа гарагийн оройн 5-7 цаг юм.

Сургуулийн Зөвлөлийн Албатай холбоо барихыг хүсвэл 703-228-6015 дугаарлуу залгах, Арлингтоны Сургуулийн Зөвлөлд 2110 Washington Blvd., Arlington, VA 22204 хаягаар захидал бичих, эсвэл school.board@apsva.us хаягт имэйл бичих боломжтой.

СУРГУУЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Доктор Барбара Ж. Каннинен, Дарга
2110 Washington Blvd., Arlington, VA 22204
Ажлын утас: 703-228-6015
(Албан үүргийн хугацаа дуусах 2022 оны 12-р сарын 31)

Рэйд Голдстэйн, Дэд Дарга
2110 Washington Blvd., Arlington, VA 22204
Ажлын утас: 703-228-6015
(Албан үүргийн хугацаа дуусах 2023 оны 12-р сарын 31)

Кристина Диаз-Торрез, Гишүүн
2110 Washington Blvd., Arlington, VA 22204
Ажлын утас: 703-228-6015
(Албан үүргийн хугацаа дуусах 2024 оны 12-р сарын 31)

Моник О'Грэйди, Гишүүн
2110 Washington Blvd., Arlington, VA 22204
Ажлын утас: 703-228-6015
(Албан үүргийн хугацаа дуусах 2021 оны 12-р сарын 31)

Дэвид Придди, Гишүүн
2110 Washington Blvd., Arlington, VA 22204
Ажлын утас: 703-228-6015
(Албан үүргийн хугацаа дуусах 2024 оны 12-р сарын 31)

СУРГУУЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨХ БҮЛГҮҮД

Сургуулийн Зөвлөл нь төрөл бүрийн зөвлөх комисс, зөвлөлөөр дамжуулан олон нийтээс зөвлөгөө авдаг. Эдгээр зөвлөх бүлгүүдийг Сургуулийн Зөвлөлөөс томилдог ба Сургуулийн Зөвлөлд зөвлөгөө өгөхөөс гадна шаардлагатай үед сургуулиудыг амжилттай явуулахтай холбоотой асуудал, бодлогуудын талаар зөвлөмж гаргадаг. Эдгээр бүлэгт:

- Зааварчилгааны талаар Зөвлөх Зөвлөл (ACI)
- Сургуулийн Барилга Байгууламж, Орчны Төслийн талаар Зөвлөх Зөвлөл
- Төсвийн талаар Зөвлөх Зөвлөл
- Сургуулийн Эрүүл Мэндийн Зөвлөх Зөвлөл (SHAB)
- Барилгын Түвшин Төлөвлөх Коммюнити

Арлингтоны Нийтийн Сургуулиудын зөвлөх бүлгүүдийн талаар нэмэлт мэдээллийг apsva.us/citizen-advisory-groups хаягаас аваарай.

АНС-Н ЖУРАМ, БОДЛОГУУД

Арлингтон Нийтийн Сургуулиудын албаны бодлого, дүрэм журмуудыг Арлингтон Нийтийн Сургуулиудын Сургуулийн Зөвлөлийн Журам (SBP) болон Бодлого Хэрэгжүүлэх Журманд (БХЖ) оруулсан байдаг. Тухайн журам, бодлогуудыг сургууль бүрийн оффис, номын сан, Арлингтоны нийтийн номын сан, Сургуулийн Зөвлөлийн Алба, 2110 Washington Blvd-д байрлах Syphax Боловсролын Төв Сургууль, Олон Нийтэй Харилцах Хэлтэс дээрээс авах боломжтой. Мөн apsva.us/school-board-policies хаягнаас авч болно.

ЭЦЭГ ЭХИЙН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Бодлого, журмын хэсэгт оруулсан бүх материал нь зайнаас суралцаж буй сурагчдад хамаарахгүй ч Виржинийн Хамтын Нөхөрлөлийн Сургуулийн тухай Хууль 22.1-279.3-н дагуу АНС нь сурагчдын эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчдад хүүхдийнх нь сургуулийн дүрэм журмуудыг танилцуулах үүрэгтэй. Үүнд “Сургууль нээгдсэнээс хуангийн нэг сарын дотор сургуулийн зөвлөл бүр нь тухайн үед тараасан бусад материалуудын хамт сургуульд элссэн сурагч бүрийн эцэг эхэд (i) энэхүү хэсэгт заасан шаардлагын талаарх мэдэгдэл; (ii) сургуулийн зөвлөлийн сурагчийн ёс зүйн стандартын хуулбар; (iii) албан боловсрол эзэмших хуулийн хуулбарыг илгээнэ. Хүлээн авсан талаарх тодорхойлолтон дээр эцэг эх гарын үсэг зурсанаар Америкийн Нэгдсэн Улс эсвэл Хамтын Нөхөрлөлийн хууль, үндсэн хуулиар хамгаалагдсан эрхээсээ татгалзаагүй ба тухайн эрхээ эдлэх эрхтэй бөгөөд аливаа эцэг эх нь сургуулийн эсвэл сургуулийн салбар нэгжийн журам, шийдвэртэй санал нийлэхгүй байгаагаа илэрхийлэх эрхтэй болохыг мэдэгдсэн мэдэгдлийг тухайн илгээх материалд оруулсан байх ёстой.

Сурагчийн эцэг эх бүр нь сургуулийн зөвлөлөөс гаргасан сурагчийн ёс зүйн стандарт, энэхүү хэсэгт заасан шаардлагын мэдэгдэл ба албан боловсрол эзэмших хуулийн хуулбарыг хүлээн авсанаа мэдэгдсэн тодорхойлолтон дээр гарын үсэг зурж сургуульдаа буцаан өгнө. Сургууль бүр тухайн тодорхойлолтуудыг хадгална.”

Энэхүү 2021-22 Арлингтон Нийтийн Сургуулиудын (АНС) Гарын авлагад АНС-н Сургуулийн Зөвлөлийн Журам, сурагчдын мөрдөх журам болон албан боловсрол эзэмшилтийн талаарх зүйлсийг оруулсан болно. АНС-н Гарын Авлагыг Жилийн Онлайн Баталгаажуулалтын Үйл явцын хүрээнд бүх сурагчдын ар гэрийнхэн олгодог бөгөөд энэхүү үйл явцын хүрээнд ар гэрийнхэн АНС-н Гарын авлагыг хүлээн авсан болохыг баталгаажуулдаг. АНС-н Гарын Авлагыг apsva.us/publications хаягнаас авах боломжтой.

ЗАХИРГААНЫ ХУВААРИЛАЛТ

Захиргааны Хуваарилалтыг Сургуулийн Зөвлөлийн Журам J-5.3.32-н дагуу хийнэ. Арлингтон Нийтийн Сургуулиуд нь Виржиниагийн Код хууль болон Сургуулийн Зөвлөлийн Журам J-5.3.30 Элсүүлэлтийн дагуу тухайн сурагч сургуульд

элсэх эрхтэй эсэхийг шийднэ. Онцгой нөхцөлд сурагчийг өөр сургууль, хөтөлбөрт хуваарилж болно. Хуваарилалтыг тухайн сурагчийн хэрэгцээ шаардлагыг Арлингтон Нийтийн Сургуулиудын үйлчилгээнд нийцүүлэх зорилгоор хийдэг. Захиргааны Хуваарилалт хийхэд дараах онцгой нөхцөл байдлуудыг бодолцож үзнэ.

- Орон нутгийн Шүүхийн Хүсэлт
- Хөтөлбөрт үргэлжлэн хамрагдах
- Сахилгын арга хэмжээ
- Боловсрол эзэмших боломжгүй байх
- Эмнэлэг, сэтгэл зүйн хэрэгцээ шаардлага
- Ар гэрийн гачигдал (гэр бүлийн гишүүн нас барах, эцэг эх/асран хамгаалагч өвчин тусах, санхүүгийн хүндрэл г.м).

Захиргааны Хуваарилалтын үргэлжлэх хугацааг тухайн нөхцөл байдалд тулгуурлан шийднэ. Хуваарилалт бүрт үргэлжлэх хугацаа, шинэчлэх шаардлага зэргийг баталж өгнө. Хуваарилалт нь ихэвчлэн тухайн хөтөлбөрийн үргэлжлэх хугацаагаар үргэлжилдэг.

Захиргааны хуваарилалт олгох хүсэлттэй холбоотой шийдвэрийг Хичээл сурлага, Сурагчийн Үйлчилгээ, Тусгай Боловсролын Албаны зохих ажилтантай ажилладаг Захиргааны Үйлчилгээний Дарга гаргадаг. Захиргааны хуваарилалтын хүсэлтийн маягыг apsva.us/school-options/administrative-placement/ хаягнаас аваарай. Нэмэлт мэдээллийг Захиргааны Үйлчилгээний Даргатай 703-228-6187 утсаар холбогдож авна уу.

Суперинтендент эсвэл хариуцагчид хандан шийдвэрийг давж заалдаж болно. Давж заалдах өргөдлийг эцэг эх/асран хамгаалагч нь бичгээр Суперинтендент/хариуцагчид гаргах ба шалтгаан, хэрэгцээ шаардлагыг тодорхой дурьдана. Суперинтендент эсвэл хариуцагч нь давж заалдах өргөдлийн хариуг журманд нийцүүлэн тодорхой боловсруулж бичгээр, цаг тухайд нь гаргаж өгнө. Хэрэв Суперинтендент/хариуцагчийн өгсөн хариу нь сурагчийн ар гэрийнхний сэтгэлд нийцэхгүй бол Сургуулийн Зөвлөлд бичгээр давж заалдаж болно. Ингэж давж заалдахдаа эмнэлэг болон/эсвэл сэтгэл зүйтэй холбоотой хүсэлт болон шаардлагатай баримт бичгүүдийг оруулна.

ЭЛСҮҮЛЭЛТ

Арлингтон Нийтийн Сургуулиудад элссэн бүх сурагч сургуулийн төлбөргүй сурахын тулд Арлингтон Дүүрэгт оршин суудаг байх ёстой. Арлингтон Нийтийн Сургуулиуд нь оршин суух газрын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагыг үе үе тавих эрхтэй байна. Дөрөвдүгээр улирал эхэлсэний дараа Арлингтон Дүүргээс шилжих Цэцэрлэгээс 12-р ангийн сурагч нь сургуулийн төлбөр төлөлгүйгээр хичээлийн жилийг дуусгаж болно. Дөрөвдүгээр улирал эхлэхээс өмнө Арлингтон Дүүргээс шилжих сурагч нь Арлингтоны оршин суугч бус, сургуулийн төлбөр төлдөг сурагчийн хувиар тухайн хичээлийн жилийг дуусгах зөвшөөрлийн хүсэлт гаргах ёстой. Дүн тавих гуравдахь үе дууссаны дараа Арлингтон Дүүргээс шилжих Төгсөх ангийн сурагч нь тухайн хичээлийн жилийг сургуулийн төлбөргүйгээр дуусгаж болно. 2005 онд баталсан мужийн хууль тогтоомжоор аливаа сургуулийн салбар нэгж, сургуульд элсэх бүсэд буй хүүхдийн оршин суух газартай холбоотой мэдээллийг санаатайгаар буруу мэдүүлсэн бол 4-р Зэрэглэлийн Зөрчлөөр шийтгэхээр заасан байдаг. Нэмэлт

мэдээллийг apsva.us/school-board-policies хаягруу орж Сургуулийн Зөвлөлийн Журам J-5.3.30-аас харна уу.

ХИЧЭЭЛ ТАСЛАХ

Хичээлээ таслахгүй байх нь амжилттай суралцахад чухал үүрэгтэй тул өвчтэй эсвэл чөлөө авсанаас бусад үед сурагч хичээлдээ хуваарийн дагуу ирж сургуулиас шаардсан бусад арга хэмжээнд оролцох учиртай. Эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээлийг таслуулах ямар нэг аялал, амралт төлөвлөхгүй байхыг зөвлөнө. Хичээлд ирэх талаарх журмыг сургуулиасаа лавлана уу. Сургуулийн ажилтнуудад сурагчдын аюулгүй байдлыг хянахад дэмжлэг үзүүлэх үүднээс хүүхэд нь хичээлд ирэхгүй бол эцэг эхчүүд сургууль урьдчилан мэдэгдэх хэрэгтэй.

Хүндэтгэн үзэх (уучлах) шалтгаангүйгээр сурагч хичээлдээ ирэхгүй байвал сургуулийн салбар нэгжийн ажилтан шүүхэд өргөдөл гаргах үүрэгтэй. Ингэсэн тохиолдолд эцэг эхчүүд насанд хүрээгүй хүүхдээ сургуульд явуулаагүйн хариуцлага хүлээнэ. Сурагч сэтгэцийн асуудлаас үүдэн хичээлдээ тогтмол ирэх боломжгүй байгаа бол сургуулийн зөвлөх ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, сурагч болон эцэг эх нь хамтран тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх хэрэгтэй. Ахлах ангийн хувьд хичээлийн ирцийн мэргэжилтэн ирцийн асуудалд тусламж үзүүлэх боломжтой.

ХҮНДЭТГЭН ҮЗЭХ ШАЛТГААН (БУСАД НЬ ХҮНДЭТГЭН ҮЗЭХ ШАЛТГААН БОЛОХГҮЙ)

- Өвчин, сурагч тусгаарлагдсан, эмч, шүдний эмчтэй цаг товлосон
- Гэр бүлийн гишүүн нас барсан
- Шашны уламжлалт баяр тэмдэглэсэн
- Шүүхэд дуудагдсан
- Сургуулиас хүчээр чөлөөлсөн
- Хүчтэй салхи шуурга, гэнэтийн нөхцөл байдал
- Ар гэрт гэнэтийн ноцтой нөхцөл байдал үүссэн
- Сургуулийн захирлаас зөвшөөрсөн бусад онцгой нөхцөл

Эцэг эх/асран хамгаалагч нь тухайн сурагчийг сургуульдаа эргэн ирсэний дараа хоёр хоногоос хэтрүүлэлгүйгээр сургуулийн албатай баталгаат холбоо барих эсвэл хичээлдээ ирээгүй шалтгааныг бичгээр өгнө. Хичээлдээ ирээгүйгээс хоцорсон хичээлийг сурагч нөхөх учиртай. Сурагч хүндэтгэх шалтгаангүйгээр хичээлээ тасалсан бол тухайн тасалсан хоногт хичээл дээр өгөгдсөн дүнгүүдээ авч чадалгүй хоцроно.

Арван тав (15) буюу түүнээс дээш өдрөөр хичээлдээ ирээгүй сурагчийг сургуулийн бүртгэлээс хасахыг мужийн хууль дүрмээр шаарддаг. Хэрэв ингэсэн бол тухайн сурагч сургуульдаа аль болох түргэн эргэн ирэх хэрэгтэй. Сурагчтай хамт эцэг эх ирж элсэлтийн шинэ маягтуудыг бөглөх ёстой.

Хэрэв сурагч эцэг эхдээ мэдэгдэлгүйгээр тав (5) хоног хичээлээ тасалсан бол Виржиниа мужийн Код хуулийн дагуу сургуулийн ажилтан, эцэг эх, сурагч нийлэн сурагчийн хичээл таслалтыг шийдэх төлөвлөгөө гаргах ёстой. Хэрэв ингэсний дараа хичээлээ тасалсаар байвал сургуулийн ажилтан Арлингтон Дүүргийн Насанд хүрээгүй Хүүхэд, Гэрийн Харилцааны Дүүргийн Шүүх болон бусад дүүргийн агентлагуудтай

хамтран тухайн сурагчийг сургуульд ирүүлэх явдлыг дэмжиж ажиллана. Сургууль бүрийн нийгмийн ажилтан нь эцэг эх, сурагчдад хичээл таслах асуудлаар тусламж дэмжлэг үзүүлэх боломжтой. Ахлах ангийн хувьд хичээлийн ирцийн мэргэжилтэн ирцийн асуудалд тусламж үзүүлэх боломжтой.

ХИЧЭЭЛЭЭС ХОЦРОХ

Бага болон дунд сургуульд багш нар хүндэтгэн үзэх шалтгаангүй хоцролтыг сургуулийн захиралд мэдэгдэн зохих арга хэмжээ авахуулна. Ахлах сургуулийн хувьд дүн тавих нэг хугацаанд гурван удаа хоцорвол нэг хүндэтгэн үзэх шалтгаангүй таслалт болно.

Сургуулийн ирцийн талаарх нэмэлт мэдээллийг apsva.us/school-board-policies хаягруу орж Сургуулийн Зөвлөлийн Журам J-5.3.30-аас харна уу.

БУСДЫГ ДЭЭРЭЛХЭХ, ДАРАМТЛАХ

Арлингтон Нийтийн Сургуулиуд нь бүх сурагчдад аюулгүй, халамжтай, хүндэтгэлтэй сурах орчинг бүрдүүлэхийг зорьж ажилладаг.

Гарал угсаа, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, нас хүйс, эдийн засгийн байдал, бэлгийн чиг хандлага, гэрлэсэн байдал, жирэмслэлт, генийн мэдээлэл, жендерийн тодорхойлолт, илэрхийлэл болон/эсвэл бие, оюун, мэдрэхүйн хөгжлийн бэрхшээлээс үүдэн эсвэл тийм шалтгаар бусдыг дээрэлхэх эсвэл дарамтлах зэргээр бусдыг дээрэлхэх эсвэл дарамтлахыг хатуу хориглох ба хүлээн зөвшөөрөхгүй болно. Бусдыг дээрэлхэх гэдгийг “хохирогчийг хүсээгүй байхад хохирогчид гэм хор учруулах, сүрдүүлэх, гутаан доромжлох зорилготой ширүүн догшин ааш авир; үйлдэгч эсвэл үйлдэгчид ба хохирогч хоёрын хооронд хүчний тэнцвэрт бус байдал байгаа мэт харагдах эсвэл бодитой байх; ахин дахин давтагдаж сэтгэл зүйн гүн цочролыг бий болгодог үйлдэл” гэж тодорхойлно. Бусдыг дээрэлхэх явдалд интернэтээр дээрэлхэх мөн багтана. Дарамтлах гэдгийг “сурагчийн хүртэх ёстой дэмжлэг тусалцаа, үйлчилгээ, боломжуудад сурагчийг оролцох, авахад саад учруулах, боломжгүй болгох сөрөг орчинг бий болгохуйц сурагчид чиглэсэн айлган сүрдүүлж хүчирхийлсэн үйлдэл” гэж тодорхойлно. Дарамтад “хэл амаар доромжлох; интернет эсвэл гар утсыг ашиглан зураг, бичгээр доромжлох; биед аюул учруулж болох, аюултай, доромжилсон бусад үйлдлүүд багтана. Дарамт нь заавал гэм хор учруулах зорилготой, тодорхой хүнд чиглэсэн эсвэл дахин давтсан байх шаардлагагүй.” Дээрэлхэх эсвэл дарамтлах үйлдэл гаргасан сурагчид захиргааны арга хэмжээ авна. Сургуулийн Зөвлөлийн Журам J-6.8.1 нь сургуулийн барилга, талбай, аялал, спортын арга хэмжээ зэрэг сургуулийн ивээн тэтгэсэн нийгмийн арга хэмжээнүүд, автобус, автобусны буудалд хамаарна. Технологийг сөрөг зохисгүй байдлаар ашиглах зэрэг сургуулийн орчноос гадна үйлдэгдсэн дээрэлхэх, дарамтлах үйлдлийг мөн хориглох бөгөөд тухайн үйлдлээс үүдэн сургууль эсвэл сурагчдын хэв журам, аюулгүй байдал алдагдсан бол захиргааны арга хэмжээ авна.

Дээрэлхүүлсэн эсвэл дарамтлуулсан гэж үзэж буй сурагчид сургуулийн ажилтан болон/эсвэл Дээрэлхэх Тохиолдлын Маягт бөглөн гомдол гаргах эрхтэй. Сургуулийн ажилтнууд тухайн явдал болсон өдөр, газар, гэрчийн нэрс болон бусад мэдээллийг цуглуулан асуудлыг даруй шалгана.

Тухайн хэрэг гарсанаас хойш хоёр хоногийн дотор хохирогчийн эцэг эх/асран хамгаалагч болон дээрэлхэх, дарамтлах үйлдэл үйлдсэн байж болох этгээдэд мэдэгдэнэ. Бүх талуудын нууцыг аль болох хадгална. Дээрэлхэх, дарамтлах үйлдлийн хохирогч болсон сурагчдад зохистой бол зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ. Захиргааны арга хэмжээнээс гадна сургуулийн ажилтнууд бусдыг дээрэлхдэг эсвэл дарамталдаг сурагчдад зүйтэй гэж үзвэл зан авираас сэргийлэх төлөвлөгөө, олон талт дэмжлэгийн багт хандах эсвэл зөвлөгөөний үйлчилгээнд хандах зэргээр тусалцаа үзүүлнэ. Нэмэлт мэдээллийг apsva.us/student-services/bully-prevention/ хаягнаас авна уу.

ӨӨРИЙГӨӨ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

ХЭВЛЭМЭЛ МАТЕРИАЛ

Арлингтон Нийтийн Сургуулиуд олон нийт санаа бодлоо солилцох газар биш тул сургуулийн хөтөлбөр, арга хэмжээнээс бусад ямар нэг бичиг материалыг хэвлэмэл материал тараахтай холбоотой Сургуулийн Зөвлөлийн Журам K-6-д заагаагүйгээс бусдаар тараахыг хориглоно.

АНС нь тухайн бодлогод зааснаар зөвхөн сургууль, Арлингтон Дүүргийн засгийн газар, АНС-н сургуулиудын эцэг эх, багшийн байгууллага болон Ашгийн Бус Байгууллагуудын болон тэдний өмнөөс бэлтгэсэн хэвлэмэл материал, судалгаа, асуулгуудыг сурагч, эцэг эх, ажилтнуудад тараадаг. Сургуульд сургуулийн хөтөлбөрөөс өөр материалыг зөвхөн дараах дөрвөн аргаар тараах боломжтой: (1) цүнхэнд хийж явуулдаг шуудан, (2) товхимол хадах болон/эсвэл байрлуулах, (3) сургуулийн барилгыг зөвшөөрлийн дагуу ашиглах үеэр тараах, (4) гадны байгууллагууд сургуулийн талбай дээр тараах. Сургуулийн хөтөлбөрийн хүрээнд бус бол бодлогод зааснаас бусад байдлаар хэвлэмэл материалыг сургуулийн талбай дээр тараахыг хориглоно.

Цүнхэнд хийж явуулдаг шуудангаар зөвхөн: Арлингтон Нийтийн Сургуулиудын эсвэл түүний өмнөөс боловсруулсан, сургуулийн асуудалтай шууд холбоотой материалууд; Арлингтон Дүүргийн засгийн газар эсвэл түүний өмнөөс боловсруулсан, Дүүргийн асуудалтай шууд холбоотой материалууд; АНС-н сургуулиудын эцэг эх багшийн байгууллагын эсвэл түүний өмнөөс боловсруулсан, тус байгууллагын асуудалтай шууд холбоотой материалууд; эсвэл бодлогод заасны дагуу (холбооны татварын хүрээнд Суперинтендент эсвэл хариуцагчид ашгийн бус статусныхаа нотолгоог олгосон байгууллагууд гэж тодорхойлогдох) ашгийн бус байгууллагын боловсруулсан материалуудыг тарааж болно.

АНС-н цүнхэнд хийж явуулдаг шууданг өөр байгууллага ашиглах боломжгүй юм. Цүнхэнд хийж явуулдаг шуудангаар олон нийтийн санал асуулгын асуултыг дэмжсэн эсвэл эсэргүүцсэн эсвэл орон нутгийн сургуулийн зөвлөл, орон нутгийн засаг захиргаа, Виржиниа Мужийн Ерөнхий Ассемблей эсвэл Америкийн Нэгдсэн Улсын Конгрессоор шийдэгдэхээр хүлээгдэж буй асуудлыг дэмжсэн эсвэл эсэргүүцсэн материалыг тараахыг хориглоно.

Цүнхэнд хийж явуулдаг шууданг долоо хоног бүр имэйлээр цахим байдлаар илгээдэг болсон ба мөн сургууль бүрийн вебсайт дээр тавигддаг болсон. Цаасан хуулбарыг мөн сургуулийн албанаас авах боломжтой.

Гадны бүлгүүдийн сурагчдад түгээлгэхээр хүсэлт гаргасан мэдэгдлүүдийг хадах болон/эсвэл байрлуулах газрыг захирлууд зааж өгч болно. Дээр заасан аргын хүрээнд тараах боломжгүй материалуудын хувьд сургуулийн барилга бүрт тус материалыг сургуулийн барилгаас гадуурх аливаа хүн эсвэл бүлгийн сургуулийн талбай дээр тараах цаг, газар, хэлбэрийг хичээлийн цаг, сургуулийн ивээн тэтгэсэн арга хэмжээд саад учруулахгүй байхаар Суперинтендент зааж өгнө.

Хичээлийн хүрээнд сурагчдын бэлтгэсэн (сонин, жилийн ном, болон сэтгүүл зэрэг) материалуудыг багш эсвэл спонсорын хяналт удирдлага дор тараана. Сурагчдын тараахыг хүсч буй энгийн хичээлийн хөтөлбөрөөс гадуурх материалыг захирлын тогтоох зохих цаг, газар, хэлбэрийн дагуу тарааж болно. Сургууль дээр материал тараахын өмнө сурагчид тухайн тараах зүйл нь хэвлэмэл материалын бодлогод нийцэж байгаа болохыг баталсан захирлын зөвшөөрлийг авна.

Хэвлэмэл материал тараах эсвэл имэйл үйлчилгээгээр мэдээлэл тараах талаарх нэмэлт мэдээллийг Сургуулийн Суперинтендентийн туслах болон Олон Нийтийн Харилцаатай 703-228-6005 холбогдон авна уу.

ҮГ ХЭЛЭХ

Хичээлийн үеэр сурагчид судалж буй сэдвээр өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй. Сурагчид нь бусад сурагчийн эсвэл сургуулийн ажилтны үзэл бодлоо илэрхийлэх эрхэд саад учруулахгүй байх үүрэгтэй.

ШАШИН ШҮТЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Сургууль нь шашны зан үйл үйлдэх эсвэл ямар нэг шашин шүтлэг, шашны үйлийг дэмжих, хорих үйл ажиллагаа явуулж болохгүй. Сурагчийн шашин шүтлэг нь бусдын эрхэнд халдаагүй эсвэл сургуулийн үйл ажиллагаанд саад учруулахгүй бол шашин шүтлэгээ хувиараа даган мөрдөж болно.

Виржиниа Хууль тогтоох байгууллагын 2008 онд баталсан хууль тогтоомжид “сурагч шашны итгэл бишрэлийнхээ талаар гэрийн даалгавар, хийсэн уран бүтээл болон бусад бичгэн болон аман даалгаварт илэрхийлж болох ба үүнийг шашны агуулгаас хамааран ялгаварлахыг хориглоно. Тухайн ангийн болон гэрийн даалгаврыг академикийн энгийн стандартаар, сургуулиас тодорхойлсон хүчин төгөлдөр сурган хүмүүжүүлэх арга зүйн асуудтай харьцуулан шүүнэ” гэж заасан байдаг.

ТОГЛООМ ШОГЛООМ ХИЙХ

Виржиниа Мужийн Ёс Зүйн Журманд ямар нэг дугуйлан, клуб, байгууллага, сурагчдын холбоонд элсүүлсэх, гишүүнчлэлийг үргэлжлүүлэх нэрийдлээр аль нэг сурагч эсвэл сурагчид сайн дураар оролцсон, үгүйгээс үл хамааран тэдний эрүүл мэнд, аюулгүй байдалд санаатайгаар эсвэл хайхрамжгүйгээр аюул учруулах эсвэл биеийн гэм хор учруулахыг хориглодог. Ямар ч сурагч ийм зорилгоор бусдаар тоглоом шоглоом хийхийг хориглоно. Сургуулийн барилга байгууламж, талбай, сургуулийн спонсорлосон арга хэмжээ, тээврийн хэрэгсэлд бусдаар тоглоом шоглоом хийхийг хориглоно. Энэ үйлдлийг харсан, үйлдлийн хохирогч болсон сурагч том хүнд хэлж зохих арга хэмжээ авахуулна. Энэ үйлдэл нь 1-р Зэрэглэлийн зөрчил бөгөөд сахилгын арга хэмжээнээс гадна шоронд 12 сар хүртэл суух эсвэл \$2,500 хүртэл долларын торгууль төлөх эсвэл хоёуланг нь ноогдуулах шийтгэлтэйгээ байдаг. Мөн дээрх үйлдлээс үүдэн биедээ гэмтэл авсан аливаа хүн буруутай этгээд эсвэл этгээдүүдийн эсрэг нас биенд хүрсэн, хүрээгүйгээс нь үл хамааран иргэний шүүхэд зарга үүсгэх эрхтэй. Биеийн гэмтэл учруулсан ийм үйлдэл тохиолдсон сургуулийн захирал тус үйлдлийг орон нутгийн Хамтын Нөхөрлөлийн Хуульчид мэдэгдэнэ. Виржиниа Мужийн Сурагчийн Ёс Зүйн Бодлого Удирдамжийг http://www.doe.virginia.gov/boe/guidance/safety/student_conduct.pdf хаягнаас харна уу.

БАГШ НАРЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭЦЭГ ЭХИЙН ЭРХ

2015 оны Сурагч Бүрт Амжилт Хуулиар (ESSA) 1-р Эрх бүхий сургуульд хүүхэд нь сурдаг эцэг эхчүүдэд хүүхдийнхээ багш нарын талаарх зарим мэдээллийг авах хүсэлт гаргах эрхийг олгодог. Хүүхдийнхээ багшийн талаар хүсэлт гарган авч болох мэдээлэлд дараах орно:

- Тухайн багш нь тухайн анги болон сэдвээр багшлах зөвшөөрлийн шалгуур болон мужийн шалгуурыг хангасан эсэх.
 - Тухайн багш нь багшлах зөвшөөрөлтэй холбоотой мужийн шалгуурыг хэрэгсэхгүй болгосон онцгой байдлын эсвэл бусад статусын дор багшлаж байгаа эсэх
 - Тухайн багш нь тухайн чиглэлээр бакалаврын зэрэгтэй, гэрчилгээтэй эсэх
 - Хичээлийг туслах мэргэжилтэн зааж байгаа эсэх, хэрэв тийм бол тухайн туслах мэргэжилтний боловсрол, ажил мэргэжлийн туршлага.
- Хэрэв та энэ сэдвээр нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл хүүхдийнхээ сургуулийн захиралтай холбогдоно уу.

ШАЛГАЛТААС ТАТГАЛЗАХ ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭЦЭГ ЭХИЙН ЭРХ

2015 оны Сурагч Бүрт Амжилт Хуулийн (ESSA) 1112(e)(2) Хэсгээр 1-р Эрх бүхий сургуульд хүүхэд нь сурдаг эцэг эхчүүдэд ESSA-аас шаардсан аливаа шалгалтад сурагч хамрагдах талаарх муж болон

нэгжийн бодлогуун талаарх мэдээлэл авах хүсэлт гаргах эрхийг олгодог. Үүнд аливаа дүрэм журам, бодлого, эцэг эх хүүхдээ шалгалтад оруулахгүй байх эрх зэрэг орно. Виржиниа мужийн нийтийн сургуульд явж буй бүх сурагч мужийн холбогдох шалгалтуудыг өгөх учиртай. Виржиниагийн хууль журманд Виржиниа мужийн шалгалт шүүлэгтэй холбоотой сурагчийн “татгалзах журам”-г оруулж өгөөгүй байдаг. Хэрэв эцэг эх нь хүүхдээ Виржиниа мужаас шаардсан нэг буюу түүнээс дээш шалгалтад оруулахаас татгалзвал хүүхдийнх нь мужийн шалгалтын оноон дээр тухайн ороогүй шалгалтад “0” тавигдахыг мэдэх хэрэгтэй. Хэрэв та энэ сэдвээр нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл хүүхдийнхээ сургуулийн захиралтай холбогдоно уу.

НЭЭЛТИЙН ДАСГАЛ

Бүх Арлингтон Нийтийн Сургуулиуд нь Виржиниа Код хуулийн 22.1-2.02, 22.1-2.03-н дагуу АНУ-н Туганд Ёслох ёслолыг өдөр бүр үйлдэх ба нэг минут нам гүм байна.

Анги болгонд Америкийн Нэгдсэн Улсын туг байна. Туганд Ёслох ёслолын үеэр сурагч баруун гараа зүрхэндээ байрлуулан тугруу харж ёслолын тунхгийг хэлэх буюу бусдад саад учруулалгүйгээр чимээгүй зогсоно. Сурагч, эцэг эх эсвэл хууль ёсны асран хамгаалагч нь шашин шүтлэг, философи, болон бусад үндэслэлээр тунхгийг хэлэхгүй гэвэл хүчээр хэлүүлэхгүй. Нам гүм байх үед сурагчид чимээгүй байх ба бусдыг үймүүлж болохгүй. Энэ цагаар сурагчид хуулиар зөвшөөрсөн чимээгүй зүйлсийг хийж болох ба дуу чимээгүй бодлоо төвлөрүүлэх боломжтой.

БЭЛГИЙН ЗОХИСГҮЙ ҮЙЛДЭЛ, ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Арлингтон Нийтийн Сургуулиудын зорилгуудын нэг бол сурагчдыг бэлгийн зүй бус үйлдэл, хүчирхийллээс хамгаалах зэргээр аюулгүй, тусалж дэмжсэн сурах орчинг бүрдүүлэх явдал юм. Сурагчдыг бэлгийн зүй бус үйлдэл, хүчирхийллээс хамгаалах хариуцлагыг салбар нэгжийн суперинтендент, сургуулийн зөвлөл, багш нар, сургуулийн бүх ажилтан, сургуулийн сайн дурын ажилтан, муж, орон нутгийн нийгмийн үйлчилгээний агентлагууд, хууль сахиулах байгууллага болон эцэг эх хамтран үүрнэ.

Сургуулийн салбар нэгжийн ажилтнууд болон сурагчдын хоорондох биеийн контакт ил тод, бэлгийн бус ба тухайн нөхцөлд тохирсон байх ёстой. Арлингтон Нийтийн Сургуулиудын ажилтнууд болон сайн дурын ажилтнууд сурагчидтай аальгүйтэх, хайр дурлалын эсвэл бэлгийн асуудлаар ярихыг хориглоно. Сургуулийн салбар нэгжийн ажилтнууд, сайн дурын ажилтнууд болон сурагчдын хооронд ямар нэг бэлгийн зүй зохисгүй хошигнол, “тоглоомоор” бэлгийн сэдвээр тоглоом хийх явдлыг хориглоно.

Бэлгийн зүй зохисгүй үйлдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам G-2.3-г онлайнаар [apsva.us/ school-board-policies](https://apsva.us/school-board-policies) хаягнаас авах боломжтой.

ХОРИОТОЙ БОДИСУУД

Арлингтон Нийтийн Сургуулиуд нь бүх сурагчдад архи тамхи, е-тамхи болон бусад цахилгаан никотин хүргэх төхөөрөмж болон хууль бус бодисгүй эрүүл мэнд сурах орчинг бүрдүүлэхийг хичээж ажилладаг. Арлингтон Нийтийн Сургуулиуд нь хууль бус архи тамхи, хар тамхи хэрэглэснээс үүдэх хор уршиг болон хууль бус хар тамхи болон бусад бодисуудыг буруугаар хэрэглэх талаар сурагчдад боловсрол олгоход чиглэсэн ажиллагаа, стратегиудыг идэвхитэй хэрэгжүүлдэг. Зан авирын эерэг интервенц, зөвлөгөө авах, зохих байгууллагуурууд хандуулах, аюулгүй, эрүүл сурах орчинг сурагчид, ажилтнуудад олгох, энэ журмыг зөрчсөн хүмүүст зохих ага хэмжээ авах тал дээр Арлингтон Нийтийн Сургуулиуд нь дүүргийн бусад агентлагуудтай хамтран ажилладаг. Арлингтон Нийтийн Сургуулиуд нь сургууль дээр сэтгэцэд нөлөөлөх бодисын буруу хэрэглээний талаар зөвлөгөө өгөх, энэ тал дээр ажилладаг байгууллагуудын мэдээллийг олгох зэргээр хэрэгцээ шаардлагатай бүх сурагчдад дэмжлэг тусалцаа үзүүлнэ.

Арлингтон Сургуулийн Зөвлөл нь сургуулийн байгууламж талбай дээр, сургуулиас ирэх очих үед, сургуулийн автобус дотор, сургуулийн зохион байгуулсан аялал, арга хэмжээ болон хоолны цагийн үеэр доор дурьдсан бодисуудыг авч явахыг хориглоно. Хориотой бодисыг (доор тодорхойлсончлон) хэрэглэсэн сурагчид Сургуулийн Зөвлөлийн Журмын J-7.4 Сурагчийн Ёс Зүйн Журмын дагуу захиргааны хариуцлага тооцох боломжтой.

Сурагчид доор жагсаасан аль нэг бодисыг авч явах, олж авахыг оролдох, ашиглах, ашиглахыг оролдох, хэрэглэх, тараах болон худалдан авахыг хориглоно.

1. Хяналтанд байдаг бодисууд буюу 21 U.S.C 812(c) хэсэг дээрх Хяналтанд байдаг Бодисны Хуулийн 202(C) хэсгийн ангилал I, II, III, IV, V-д тодорхойлсон мансууруулах бодис болон бусад бодисууд.
2. Хууль бус бодис гэж хяналтанд байдаг бодисуудыг хэлэх боловч хуулийн дагуу авч болох хяналтанд байдаг бодис болон тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн мэргэжилтний хяналтан доор хэрэглэдэг эсвэл Хяналтанд байдаг Бодисны Хууль болон холбооны хуулийн аль нэг бусад заалтын дагуу аливаа бусад эрхийн доор хуулийн дагуу байлган хэрэглэдэг бодисууд орохгүй.
3. Хориглож хязгаарласан бодист архи, тамхины бүтээгдэхүүн, никотин уурны бүтээгдэхүүнүүд болон бусад орно. Анаболик стероид, сэргээш, сэтгэл гутралд оруулагч бодис, хий зүйлс харуулагч бодис, марихуан, дуураймал эмүүд, хар тамхины хэрэгслүүд болон энэхүү журмыг зөрчсөн аливаа жороор олгодог болон жороор олгодоггүй бодис зэрэг Виржиниа Код хуулийн 54-р Гарчиг 15.1-р Бүлэг, Эмийн бодис хяналтын Хуульд тодорхойлсон сордог бүтээгдэхүүн болон бусад хяналтанд байдаг бодисууд.

Үнэртдэг цавуу зэрэг хуулиар зөвшөөрсөн бодисыг буруу, туйлшруулан, зүй зохисгүйгээр хэрэглэх, жоргүй олгодог эмийг зөвлөмжөөс хэтрүүлэн хэрэглэх, өөр хүнд жороор олгосон эмийг хэрэглэх зэргийг хориглоно.

Хяналтад байдаг бодис болон дуураймал бодисыг баглаж боох, хадгалах, дахин баглах, агуулах, нуух, тарих, сорох, идэх болон бусад байдлаар биед нэвтрүүлэх зориулалттай сэтгэгдэхэд нөлөөлөх бодисны хэрэгсэл буюу тоноглол, бүтээгдэхүүн, материал, эд ангийг чиедээ авч явахыг хориглоно.

Хуулийн дагуу зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн мэргэжилтний хяналтан дор эсвэл Хяналтанд байдаг Бодисны Хууль эсвэл холбооны хуулийн аль нэг бусад заалтын дагуу хяналтанд байдаг бодисыг авч явах эсвэл хэрэглэх нь зөрчил болохгүй. Хяналтанд байдаг бодис эсвэл жоргүй олгодог эмийг Сургуулийн Зөвлөлийн Журам J-8.3.1 Сургуулийн Эрүүл мэндийн Үйлчилгээний заалтын дагуу сурагч авч явах, хэрэглэхийг хориглохгүй.

СУРАГЧИЙН БЭЛГИЙН ДАРАМТ, БЭЛГИЙН ГАДУУРХАЛ – IX ЗЭРЭГ

Арлингтон Нийтийн Сургуулиуд нь ямар нэг төрлийн бэлгийн ялгаварлал гадуурхал, бэлгийн дарамтгүй сурах орчинг олгоно. Ялгаварлал, дарамтын ямар нэг хэргийг мэдэгдэх, үнэн бодит гомдол гаргах, хэрэг, гомдлыг шалгахад оролцооноороо сурагч шийтгүүлэх ёсгүй. Нууцлалыг дээд зэргээр хадгална. Батлагдсан гомдолд зохих сахилгын арга хэмжээ авна.

Насанд хүрэгчид эсвэл найз нөхөд нь ялгаварласан, дарамталсан бол сургуулийн захиргааны ажилтанд даруй мэдэгдэх хэрэгтэй. Сургуулийн захирал эсвэл хариуцагч нь аливаа ялгаварлал, дарамтын гомдлыг даруй шалган гомдлыг шийдвэрлэх зохих арга хэмжээг авах ба зохистой бол түр арга хэмжээг авна. Бусдыг ялгаварласан, дарамталсан сурагчид зохих сахилгын арга хэмжээ авна.

Хүсээгүй бэлгийн шинжтэй үйлдэл, бэлгийн үйлдэл хийхийг хүсэх, бэлгийн шинжтэй аман, бичгэн, биет үйлдэл болон бэлгийн чиг хандлага, жендерийн тодорхойлолт, илэрхийлэлд суурилсан дарамт нь сурагчийн хичээл сурлагад саад болсон, айдас хүргэсэн, таагүй, сөрөг сурах орчинг үүсгэсэн бол үүнийг бэлгийн дарамт гэнэ. Бэлгийн дарамтад хүчин, бэлгийн хүчирхийлэл, дагаж мөрдөх, болон үүнтэй ойролцоо зөрчлүүд багтана. Сургуулийн Зөвлөлийн Журам J-2-г apsva.us/school-board-policies хаягнаас харна уу.

Захиргааны Үйлчилгээний Дарга болон IX Зэргийн Зохион байгуулагч нь сурагчдын бүх ялгаварлалтай холбоотой гомдлуудыг Шийдвэрлэх Ажилтан байна. IX Зэргийн Зохион байгуулагч нь бэлгийн дарамт/бэлгийн гадуурхалтай холбоотой шалгалтыг хянах ба АНС-н IX Зэргийн хяналт, мөрдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Эрүүл мэнд, Биеийн Тамирын Ахлах ажилтан нь сурагчдын спорт биеийн тамиртай холбоотой IX Зэргийн Зохион байгуулагч байна. Захиргааны Үйлчилгээний Дарга нь бэлгийн дарамт/бэлгийн гадуурхалтай холбоотой аливаа гомдлыг шийдвэрлэнэ.

СУРАГЧИЙГ ЖЕНДЕРИЙН ТОДОРХОЙЛОЛТООР ГАДУУРХАХГҮЙ БАЙХ

АНС нь аюулгүй, сурагчдыг урин дуудсан, үнэлж хүлээн зөвшөөрсөн сургуулийн орчинг бүрдүүлэн идэвхтэй суралцдаг, сургуулийн үйл ажиллагаануудад оролцдог байлгах зорилготой. Сургуулийн бүх ажилтан, сурагчид трансжендер, жендерийн хувьд өөр чиг хандлагатай гэж өөрийгөө тодорхойлдог сурагчид зэрэг жендерийн тодорхойлолттой холбоотой асуудлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэх болон тухайн сурагчид жендерийнхээ тодорхойлолтыг санаа зоволгүй илэрхийлдэг байх нь чухал юм. Биеийн тамирын хичээл, хөгжмийн чуулга, жилийн номын зураг, хүндэт нийгэмлэгийн ёслол, дэмжих ёслол, бүжиг зэрэгт сургууль нь аль болох жендерийн хувьд төвийг барьсан дүрэмт хувцсыг мөрдлөг болгохыг бодолцон үзэх хэрэгтэй.

Сургуулийн Зөвлөлийн Журам J-2-н дагуу гарал угсаа, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, нас хүйс, эдийн засгийн байдал, бэлгийн чиг хандлага, гэрлэсэн байдал, жирэмслэлт, генийн мэдээлэл, жендерийн тодорхойлолт, илэрхийлэл болон/эсвэл хөгжлийн бэрхшээлээс үүдэн ялгаварлахыг АНС-аас хориглоно.

СУРГУУЛИАС ГАРАХ (СУРГУУЛИА ХАЯХ)

Виржиниа мужийн Хуульд зааснаар сурагчид 6 наснаас 18-н насны төрсөн өдөр хүртэл сургуульд сурах шаардлагатай. Сургуулиас эрт гарах хүсэлтэй сурагчид Сурагчийн Үйлчилгээний Даргатай 703-228-6058 утсаар холбогдох хэрэгтэй. Төгсөх зорилготой сурагчид 20-н насны төрсөн өдрөө хүртэл нийтийн сургуульд сургуулийн хичээлийн жилийн хуваариар (9-р сараас 6-р сар хүртэл) үргэлжлүүлэн суралцаж болно. Тусгай боловсролын үйлчилгээ авч буй сурагчид 9-р сарын 30-ны дараа 22 нас хүрэх бол 22 нас хүртэл сургуульд сурч болно. Унаган Англи хэлгүй, 12 нас хүрсэний дараа анх удаа Виржиниа мужийн сургуульд орсон ба хичээлийн жилийн 8-р сарын 1 эсвэл түүнээс өмнө 22 нас хүрээгүй сурагч сургуульд суралцаар байж болно. Арлингтон Дүүргээс нүүж буй гэр бүл хүүхдийнхээ сургуульд шинэ хаяг, утасны дугаараа өгөх ёстой. Нэмэлт мэдээллийг Сурагчийн Үйлчилгээний Албатай 703-228-6058 дугаараар холбогдон авна уу.

АНС-Н СУРАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ БА ЁС ЗҮЙН ЖУРАМ

Арлингтон Нийтийн Сургуулиуд нь сургуулийн хамт олны бүх гишүүдийн эрхийг АНУ-н хууль болон Виржинийн Хамтын Нөхөрлөлийн хуулиар олгогдсоны дагуу хамгаалж ажиллана. Арлингтон Нийтийн Сургуулиуд нь сурагч, багш, ажилтнуудын үндсэн эрхийг хүлээн зөвшөөрдөг ба бүгдэд суралцах боломж бүхий орчинг бүрдүүлэхийг зорино. Сурагчийн амжилт гэж хичээл сурлагаас гадна сурагчийн бие сэтгэлийн эрүүл байдал, урт хугацааны зэрэг хөгжлийг мөн хэлнэ. Арлингтон Нийтийн Сургуулиуд нь

сурагч бүрийг эрүүл аюулгүй, тусалж дэмждэг сурах орчинд суралцан өсөн дэвжих, тухайн хүүхдийг цогц байдлаар буюу оюун ухаан, бие, сэтгэл, зан авир, нийгэм-сэтгэл зүйн хувьд өсч хөгжихийг нь тэтгэж ажиллана.

Арлингтон Нийтийн Сургуулиудын Ёс Зүйн Журманд сурагчийн сурлагыг дэмжих эерэг, урьдаас тооцсон стратеги, интервенц болон зан авир засах ажиллагаа зэргийг оруулж өгсөн байдаг. Сурагчийн Ёс Зүйн Журмыг хэрэгжүүлэхдээ Арлингтон Нийтийн Сургуулиудын эрхэм зорилго, алсын хараа, стратегийн зарчмууд болон ижил тэгш, гадуурхалгүй орчинг бүрдүүлэх зорилгыг мөрдлөг болгоно.

Арлингтон Нийтийн Сургуулиудын Ёс Зүйн Журам нь Нийгэм-Сэтгэл Зүйн Боловсролын Хамтралын (CASEL) загварт суурилсан нийгэм-сэтгэл зүйн боловсролын онолд түшиглэдэг ба дараах таван гол чиглэлд хүүхэд залуучуудын чадварыг хөгжүүлэхэд анхаарч ажилладаг: өөрийгөө мэдэх, өөрийгөө удирдах, нийгмээ мэдэх, харилцааны ур чадвар, хариуцлагатай шийдвэр гаргалт. Зан авирын асуудлыг шийдэхдээ эерэг зан авирыг хөгжүүлэх тал дээр анхаарахаас гадна дээрх таван чиглэлд сурагчийн нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээ шаардлагыг бодолцож үзэх ёстой.

Арлингтон Давхар Дэмжлэгийн Системүүд зэрэг төрөл бүрийн зан авирыг дэмжих, засах ажиллагаа, эерэг интервенцийг сурагчдад олгон сурагч бүрт суралцаж өсч хөгжих боломжийг олгоно. Хэрэв аль нэг сурагч суралцах орчны аюулгүй байдалд нөлөөлөх зан авир гарган зан авир засах ажиллагаа, бусад интервенцүүд амжилт олоогүй бол захиргааны арга хэмжээ авах шаардлагатай байж болно. Арлингтон Нийтийн Сургуулиудын Зөвлөлийн Журам Ижил тэгш байдал А-30-н дагуу Арлингтон Нийтийн Сургуулиудын бүх захиргааны ажилтан, багш, бусад ажилтнууд нь сурагчийн зан авирт авах арга хэмжээгээ ижил тэгш байлгаж суралцах орчинд зохистой эмх цэгцтэй, аюулгүй орчинг бүрдүүлэх ёстой. Сургуулийн аливаа хариуцлагатай ажилтан сурагчийн зан авирт шаардлагатай, зохистой, ижил тэгш гэж үзсэн тохиолдолд мужийн хууль болон Сургуулийн Зөвлөлийн журмын дагуу хариу арга хэмжээ авах хэрэгтэй байж болно. Сурагчийн Эрх Үүрэг: Сурагчийн Ёс Зүйн Журмын Гарын авлагыг жил бүр шинэчлэн нийтлэх ба Испани, Амхарик, Араб, Монгол хэлээр орчуулан сурагч, эцэг эх/асран хамгаалагч, ажилтнуудад түгээнэ. Бүгдийн аюулгүй байдал, тав тухын төлөө Арлингтон Нийтийн Сургуулиудын Ёс Зүйн Журам нь дараах газруудад хэрэгжинэ:

1. Сургуулийн талбай;
2. Сургуулийн талбайн ойролцоо;
3. Сургуульд ирэх очих үед;
4. Сургуулийн эзэмшлийн, ажиллуулдаг эсвэл гэрээт автобусан дээр;
5. Алсын зайн сургалт зэрэг сургуулийн талбай дээр болон бусад газар сургуулийн зөвшөөрч хянаж буй үйл ажиллагаанд оролцох;

6. Сургуулиас гадуурх үйлдлээс үүдэн сургууль, сурагч, ажилтнуудын аюулгүй байдал, тав тух алдагдсан бол;
7. Сургуулиас олгосон эсвэл сургуулийн бус технологийг ашигласан нь сурагч болон/эсвэл ажилтнуудын аюулгүй байдал, тав тухад сөргөөр нөлөөлсөн бол;

ЭЦЭГ ЭХТЭЙ УУЛЗАХ

Сурагчийн зохих зан авирын талаар эцэг эхчүүдэд даруй мэдэгдэн ярилцахын тулд эцэг эх/асран хамгаалагч нартай хурал товлоно.

ЧӨЛӨӨЛӨЛТ/ЗАХИРГААНЫ АРГА ХЭМЖЭЭНЭЭС ӨӨР АРГА ХЭМЖЭЭ

Шинэ эерэг зан авирыг заах сэтгэл зүй, сэтгэл хөдлөл, биеийн аюулгүй байдлыг олгодог аюулгүй, дэмжиж тэтгэдэг сургуулийн орчинг бүрдүүлэхийн тулд зан авирын интервенц, эерэг дэмжлэгийн стратегид бүх хүний хооронд эрүүл харилцааг бий болгох явдлыг оруулж өгсөн байдаг. Хэрэв эцэг эхтэй хамтран хийсэн интервенц, хамтын ажиллагаа амжилтгүй болвол багш нь сурагчийг сургуулийн ажилтан, захиргааны ажилтан, эцэг эх/асран хамгаалагчтай хийх Сурагчийг Дэмжих Багийн хуралд оруулж интервенцийн төлөвлөгөө зохистой эсэхийг шийднэ.

Засах ажиллагаа нь эрүүл харилцааг тэтгэн, гэм хорыг засч, зөрчлийг хувирган тэгш байдлыг дэмжихэд тус болох сурагчдад олгодог интервенц, дэмжлэгийн нэг жишээ юм. Интервенц болгон ашигласан үед сурагчийн зан авирыг засах арга нь зан авиртай холбоотой асуудал үүссэн тохиолдолд асуудаг үндсэн асуудлыг өөрчилдөг. Хэнд буруу өгөх вэ, яаж шийтгэх вэ гэж асуухын оронд засах арга нь зөв зүгт чиглүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ гэдгийг тодорхойлдог.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ЗОРЧУУЛАХГҮЙ БАЙХ

Сургуулийн тээвэрт суух эрхтэй сурагч нь сургуулийн автобус, сурагч болон бусад зорчигчдын аюулгүй байдалд аюул учруулах үйлдэл гаргасан бол захирал эсвэл хариуцагч нь тухайн сурагчийг тээврээр зорчуулахгүй байх шийдвэрийг гаргаж болно.

Хувьчилсан Боловсролын Хөтөлбөрийн (IEP) дор эсвэл Хэсэг 504 Төлөвлөгөөний дор тээврээр зорчдог хөгжлийн бэрхшээлтэй сурагч автобусан дээр зохисгүй үйлдэл гарган зорчих эрхгүй болсон бол IEP-н хяналт хийж тухайн сурагчийн үйлдэл нь хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй эсэхийг тогтооно. Хэрэв тухайн үйлдэл нь хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй бол сурагчийг тусгай боловсролын хөтөлбөрт хамруулахаас татгалзахгүй байх ёстой ба тээврийн өөр үйлчилгээг гаргаж өгнө.

СУРАГЧИЙГ АНГИД СУУЛГАХГҮЙ БАЙХ

Анги доторх суралцах эерэг орчинд саад болох зан авирыг хянаж шийдэх үр дүнтэй стратегиудыг багш нар хэрэгжүүлэхдээ тухайн сурагчийн хэрэгцээ шаардлага, IEPs-д тодорхойлж заасан хэрэгцээ шаардлага болон бусад боломжит дэмжлэгүүдийг бодолцож үзнэ. Эдгээр стратегиудыг хэрэгжүүлсэний дараа тухайн зан авир суралцах орчинг үргэлжлүүлэн үймүүлсээр байвал багш нар сурагчийг түр хугацаагаар ангид суулгахгүй байх эрхтэй байна. “Үймүүлэх зан авир” гэж Сургуулийн Зөвлөлийн журам эсвэл сурагчийн ёс зүйн Суперинтендентийн олгосон Журам Хэрэгжүүлэх Ажиллагааг (PIPs) зөрчсөн суралцах орчинд саад учруулж бусниулах үйлдлийг хэлнэ. Сурагч үймүүлсэнээс болоод багш түүнийг ангид суулгахгүй байх шийдвэрийг гаргавал дараах хүчин зүйлүүдийг бодолцож үзнэ:

1. Сурагчийн зан авираас үүдэлтэйгээр суралцах орчин саатсан бөгөөд үүнийг хэвийн байдалд оруулахын тулд сурагчийг ангид суулгахгүй шаардлагатай байх
2. Багш болон/эсвэл захиргааны ажилтнуудын интервенц сурагчийн үймүүлэлтийг зогсоож чадаагүй
3. Сурагчийн ангид үймүүлсэн ба багш/сургуулийн захиргааны ажилтнуудтай уулзах мэдэгдлийг эцэг эхэд өгсөн байх ёстой.

Дээрх шалгуур үзүүлэлтүүд хангагдсан бол багш сурагчийг ангид суулгахгүй байж болно.

“ХОЁР ДАХЬ БОЛОМЖ” ХӨТӨЛБӨР

АНС-н Хориотой Бодисны Журмыг анх удаа зөрчсөн сурагчийг сургуулиас түр чөлөөлөлгүй “Хоёр дахь Боломж” хөтөлбөрт оруулж болно. Хориотой бодис хэрэглээний журмыг зөрчиж сургуулиас түр чөлөөлөгдсөн сурагч “Хоёр дахь Боломж” хөтөлбөрт орж энэхүү эртнээс сэргийлэх боловсролын хөтөлбөрийн ашиг тусыг авч болно. Энэ нь эрчимт, эртнээс сэргийлэх хөтөлбөр ба засах ажиллагаа, сэтгэцэд нөлөөлөх бодисны хэрэглээний аюулын талаар сурагч, эцэг эхчүүдэд боловсрол олгох, ирээдүйн хэрэглээнээс урьдчилан сэргийлэх зэрэг зүйлс багтана. Энэхүү хөтөлбөрийг амжилттай дүүргэн, шалгалт, зохистой зан авирын бүх шаардлагуудыг хангасан сурагчийг тухайн хориотой бодисны журмын зөрчлөөс үүдэн сургуулиас түр чөлөөлөлгүй. Харин сурагч тухайн хөтөлбөрийг амжилттай дүүргээгүй ба шалгалт хурлуудын шаардлагыг хангаагүй бол сурагчийг сургуулиас түр чөлөөлнө.

СУРГУУЛИАС ТҮР ЧӨЛӨӨЛӨХ

Сургуулиас түр чөлөөлнө гэдэгт сургуулийн бүх үйл ажиллагаанаас түр чөлөөлөх, сургуулийн талбай дээр оруулахгүй байх, автобусанд суулгахгүй байх зэрэг орох ба хэн нэгэнд гэмтэл, хор уршиг учруулна гэж заналхийлсэн бол зөвшөөрөлгүй нэвтэрсэн гэх зөрчилд тооцно.

Сургуулийн захиргааны ажилтан/хариуцагч нь сурагчийг дээд тал нь 10 хоног, Суперинтендент/хариуцагч нь 45 хүртэлх хоногоор сургуулиас түр чөлөөлж болно. (i) тухайн зөрчил нь § 22.1-277.07 эсвэл 22.1-277.08-д тодорхойлсон зөрчил буюу биеийн ноцтой гэмтэлтэй холбоотой бол эсвэл (ii) Сургуулийн Зөвлөл эсвэл Суперинтендент/хариуцагч нь Виржиниа мужийн Код хуульд тодорхойлсончлон ноцтой нөхцөл байдал байгаа гэж үзвэл сургуулийн 45 хоногоос дээш боловч хуанлийн 364 хоногоос үл хэтрэх хугацаагаар чөлөөлж болно.

Сурагчийг сургуулийн өдөр сургуулиас чөлөөлөхийн өмнө ямар ч тохиолдолд эцэг эх/асран хамгаалагчтай холбоо барина. Хэрэв сурагчийг зан авирын асуудлаар сургуулийн өдөр гэрлүү нь явуулбал сургуулиас түр чөлөөлөхтэй холбоотой бүх журмыг мөрдөнө.

Давтамж, ноцтой байдлаас шалтгаалан сургуулиас түр чөлөөлөх, (холбогдох сургуулийн зөрчлөөс үүдэн) Хоёр дахь Боломж Хөтөлбөрт оруулах, эсвэл нэг буюу түүнээс дээш ангийн цагаар сургууль дээр түр чөлөөлөх арга хэмжээг дараах шалтгаанаар авна:

1. Тусгаарлах арга хэмжээг биелүүлээгүй;
2. Цахилгаан харилцаа холбооны төхөөрөмжийг (жишээ нь: гар утас, пэйжер зэрэг) бусдад саад учруулахуйц байдлаар хэрэглэсэн;
3. Барилга дотор, талбай дээр, автобусан дотор эсвэл сургуулийн спонсорлосон үйл ажиллагаа, аялалд зохисгүй зан авир гаргасан;
4. Амаар болон бичгээр хараал хэлсэн эсвэл аливаа хүний арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, угсаа гарал, хөгжлийн бэрхшээл эсвэл оюуны чадвар эсвэл бэлгийн чиг хандлагыг доромжилсон эсвэл доромжлох зорилготой үг хэл;
5. Сургуулийн талбай дээр тамхи, е-тамхи татах, биедээ авч явах;
6. Хяналтанд байдаг бодисыг биедээ авч явах эсвэл хэрэглэсэн байх;
7. Архи биедээ авч явах эсвэл хэрэглэсэн байх;
8. Бичиг, гарын үсэг дуурайлган үйлдэх, бусдыг хуулах, хуурч мэхлэх;
9. Мессеж, онлайн аар дээрлэх зэргээр технологи (интернет) буруу эсвэл зохисгүй байдлаар ашиглах;
10. Насанд хүрэгчдийн сонин сэтгүүл, материал биедээ авч явах;
11. Бусад сурагч, ажилтнуудад бэлгийн дарамт учруулах;
12. Мөрийтэй тоглох;
13. Шаардлага үл биелүүлэх, хэл амаар доромжлох;
14. Сурагч, ажилтныг хэл амаар доромжлох;
15. Жороор олгодоггүй эм болон бусад бодис зэрэг хуулиар зөвшөөрсөн бодисыг буруу эсвэл хэтрүүлэн хэрэглэх;
16. Өмч хөрөнгийг зориуд эвдэлж сүйтгэх (сурагч эвдрэлийг нөхөн төлөх шаардлагатай болж болно) ;
17. Сурагч эсвэл ажилтнуудын биеийн аюулгүй байдалд аюул учруулахаар сүрдүүлсэн эсвэл аюул учруулахуйц үйлдэл гаргасан;
18. Зодоон цохион хийх;
19. Бусдыг үгээр болон амаар айлган сүрдүүлсэн эсвэл биед гэмтэл учруулах зэргээр бусдыг дээрлэхсэн;
20. Сургуулийн бусад журмыг зөрчсөн эсвэл сургуулийн үйл ажиллагааг үймүүлсэн
21. Бусад үймүүлсэн шинжтэй зан авир;

22. Гангстер тэмдэг, гарын дүрс зэргийг хэрэглэх, бүлэглэн аюул занал бүхий зан авир гаргах, гангстер гэж тодорхойлсон бүлэглэлийг төлөөх зэргээр гангстер бүлэглэлийн үйл ажиллагаа явуулах;

23. Зэвсэг шиг харагдах зүйлс биедээ авч явах.

Хууль зөрчсөнөөс үүдэн сургуулиас даруй чөлөөлөн цагдаа болон/эсвэл гал командад хандах шалтгаануудад дараах орно:

1. Хяналтанд байдаг бодисыг зарах эсвэл тараах зорилгоор биедээ авч явах (сургуулиас хөөх зөвлөмж гаргана);
2. Хяналтанд байдаг бодисыг зарах, худалдан авах эсвэл тараах (сургуулиас хөөх зөвлөмж гаргана);
3. Галт зэвсэг биедээ авч явах (сургуулиас хөөх зөвлөмж гаргана);
4. Архи худалдах эсвэл тараах;
5. Бусад зэвсэг (галт бус) биедээ авч явах;
6. Сургуулийн ажилтангийн биед халдсан;
7. Олуулаа нийлж үймээн самуун үүсгэсэн;
8. Гал тавьсан, сюют/тэсрэх бодис биедээ авч явсан;
9. Хуулийн бусад зөрчлүүд.

СУРГУУЛИАС ЧӨЛӨӨЛӨХ ХУГАЦАА:

1. 3-р түвшний зан авир гаргасан бол дээд тал нь дараалсан 3 хоног сургуулиас чөлөөлнө.
2. 3-р түвшний зан авирыг давтан гаргавал дээд тал нь дараалсан 5 хоног сургуулиас чөлөөлнө.
3. 4-р түвшний зан авир гаргасан бол дараалсан 10 хүртэл хоног сургуулиас чөлөөлнө.
4. 4-р түвшний зан авирыг давтан гаргасан бөгөөд цагдаа арга хэмжээ авсан бол дараалсан 10 хүртэл хоног сургуулиас чөлөөлөх ба нэмэлт хугацаагаар чөлөөлөх захиргааны хуралд оруулах хүсэлт гаргах ба/эсвэл сургуулиас хөөх зөвлөмж гаргана.
5. 5-р түвшний зан авир гаргасан буюу Виржиниа мужийн Код хуульд тодорхойлсон маш ноцтой зөрчил гаргасан бол Суперинтендент/хариуцагч 45 хүртэлх хоногоор сургуулиас чөлөөлж болно. Сурагчийг 10-аас дээш хоногоор сургуулиас чөлөөлөхдөө Виржиниа мужийн Код хуульд тодорхойлсон дараах хүчин зүйлсийг бодолцож үзнэ:
 - a. Зөрчлийн шинж чанар, хүнд хөнгөн байдал;
 - b. Сурагчийн хичээл сурлага, ирц, сахилгын бүртгэл;
 - c. Сурагч сургуулийн журмыг зөрчсөнөө хүлээн зөвшөөрсөн эсэхийг үнэлж дүгнэн сурагчийн цаашдын үйлдлийн талаарх санаа зорилгыг бодолцож үзнэ.
6. (i) тухайн зөрчил нь § 22.1-277.07 эсвэл 22.1-277.08-д тодорхойлсон зөрчил буюу биеийн ноцтой гэмтэлтэй холбоотой бол эсвэл (ii) Сургуулийн Зөвлөл эсвэл Суперинтендент/хариуцагч нь Виржиниа мужийн Код хуульд тодорхойлсончлон ноцтой нөхцөл байдал байгаа гэж үзвэл сургуулийн 45 хоногоос дээш боловч хуанлийн 364 хоногоос үл хэтрэх хугацаагаар чөлөөлж болно.

7. Энд заасан зүйлсийн аль нь ч Сургуулийн Зөвлөлийг тухайн чөлөөлсөн хугацаагаар Сургуулийн Зөвлөлийн олгосон боловсролын өөр хөтөлбөрт тухайн сурагчийг суулгахыг зөвшөөрөх эсвэл шаардахыг хорихгүй.
8. Маш ноцтой зөрчлийн хувьд сургууль нь дараах зүйлсийг бодолцож үзнэ:
 - a. Шүүхэд хандах
 - b. Өөр хөтөлбөр; болон/эсвэл
 - c. Эцэг эх/асран хамгаалагч, сурагч, тухайн сургуулийн зохих ажилтнуудыг төлөөлөгч нартай уулзан тухайн сурагчийн ирээдүйн боловсролын хөтөлбөрийн талаар шийдэл гаргах хүсэлтийг Суперинтендент тавих.

СУРГУУЛИАС ЧӨЛӨӨЛӨХ МЭДЭГДЭЛ, ШИЙДВЭР ГАРГАХ ХУРАЛ

Сургуулийн захиргааны ажилтан сурагчийг 10 буюу түүнээс бага хоногоор сургуулиас чөлөөлж болно. Эцэг эх/асран хамгаалагч нарт сурагчийг сургуулиас чөлөөлсөн талаар даруй мэдэгдэх ба зохистой гэж үзвэл Суперинтендент/хариуцагч нэмэлт сахилгын арга хэмжээ авах талаар бодолцож үзэж болно. Эхний мэдэгдлийг цахим эсвэл утсаар өгөх ба үүний дараа Англи, Испани, Араб, Амхарик эсвэл Монгол хэлээр бичгээр хүргүүлнэ. Мэдэгдэлд үйл явцын талаарх мэдээлэл, сургуулийн ажилтанд мэдэгдэж буй баримтууд болон тухайн сурагч тэдгээр баримтуудыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд юу болсон талаар тайлбарлаж сургуулиас чөлөөлүүлэхгүй байх хүсэлт гаргах боломжтой зэрэг зүйлсийг багтаана. Хэрэв сурагч сургууль дээр ирэх нь хүн эсвэл өмч хөрөнгөд шууд эсвэл ирээдүйн аюул эсвэл үргэлжилсэн саад учруулахаар бол сурагчийг сургуулиас даруй чөлөөлж хэрэг явдлын талаарх баримт, давж заалдах, сурагчид тайлбар өгөх боломжийг өгүүлсэн мэдэгдлийг аль болох түргэн хүргүүлнэ. Захирлын туслах эсвэл хариуцагч чөлөөлөлтийг даруй давж заалдвал сургуулийн захирал хянаж шийдвэр гаргана. Хэрэв эцэг эх/асран хамгаалагч захирлын шийдвэрийг давж заалдах хүсэлтэй бол Захиргааны Үйлчилгээний Даргын нэр, албан тушаал, холбоо барих мэдээллийг тэдэнд өгөх ба сургуулиас чөлөөлсөнөөс хойш 10 хоногийн дотор давж заалдах боломжтой байна. Захиргааны Үйлчилгээний Даргын шийдвэрийг Суперинтендент/хариуцагчид давж заалдах эрхтэй болохыг сурагч болон/эсвэл эцэг эх болон/эсвэл асран хамгаалагчид мэдэгдэнэ.

ЗАХИРГААНЫ АРГА ХЭМЖЭЭГ ДАВЖ ЗААЛДАХ

СУРГУУЛИАС ЧӨЛӨӨЛСӨНИЙГ ДАВЖ ЗААЛДАХ

10 буюу түүнээс доош хоногоор сургуулиасаа чөлөөлөгдсөн сурагчийн эцэг эх/асран хамгаалагчид шийдвэрийг давж заалдах үйл явцын талаарх мэдээллийг Англи, Испани, Амхарик, Араб, эсвэл Монгол хэлээр өгнө.

Сургуулиас чөлөөлөх шийдвэрийг захирлын туслах эсвэл хариуцагч гаргасан бол сургуулийн захиралд даруй давж заалдаж болно. Хэрэв захирлын шийдвэрийг давж заалдахыг хүсвэл шийдвэр гарсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Захиргааны Үйлчилгээний Даргад бичгээр давж заалдаж болно. Ингэсэн тохиолдолд хурал хийж Захиргааны Үйлчилгээний Дарга хурал болсоноос хойш ажлын 7 хоногийн дотор бичгээр хариу өгнө. Захиргааны арга хэмжээг давж заалдахад энэхүү журмын тухайн захиргааны арга хэмжээнд хамаарах хэсэгт заасан ажиллагаа мөрдөгдөнө. Сурагчийг сургуулиас чөлөөлсөнийг сурагчийн сургуулийн бүртгэлд бүртгэх ба буруу оруулаагүй эсвэл шийдвэрийг буцаагаагүй бол бүртгэлээс устгахгүй. 10 хоногоос дээшхи чөлөөлөлт эсвэл сургуулиас хөөх асуудлаас бусад захиргааны арга хэмжээнд гаргасан Захиргааны Үйлчилгээний Даргын шийдвэр эцсийнх байна. Давж заалдалтын эцсийн шийдвэр гартал чөлөөлөлтийг хэрэгжүүлэхгүй.

УРТ ХУГАЦААГААР СУРГУУЛИАС ЧӨЛӨӨЛӨХ ЭСВЭЛ ӨӨР ХӨТӨЛБӨРТ ХАМРУУЛАХ ШИЙДВЭРИЙГ ДАВЖ ЗААЛДАХ

Сурагчийг 10 хоногоос дээш сургуулиас чөлөөлөх эсвэл өөр хөтөлбөрт хамруулах бол Захиргааны Үйлчилгээний Даргын шийдвэрийг Суперинтендент/хариуцагчид давж заалдаж болно. Суперинтендент/хариуцагчийн шийдвэр гарсанаас ажлын 10 хоногийн дотор Сургуулийн Зөвлөлд давж заалдаж болно. Сургуулийн Зөвлөл нь давж заалдсанаас хойш 30 хоногийн дотор Сургуулийн Зөвлөлийн албан дотор шийдвэр гаргана. Сургуулийн Зөвлөлийн Нярав шийдвэрийн хуулбарыг Суперинтендент/хариуцагчид өгнө. Сурагчийн тухайн хэрэгт оролцсон оролцоо маргаантай байгаагаас үүдэн доор зааснаас бусдаар 365 хоногоос бага хугацаагаар сурагчийг сургуулиас чөлөөлсөн эсвэл өөр хөтөлбөр оруулсан шийдвэрийг давж заалдсан тохиолдолд ажлын тав хоногийн дотор Суперинтендент/хариуцагч нь сургуулиас чөлөөлөх болсон шалтгаан болон сахилгын арга ажиллагааны бүртгэлийг дагалдуулан Сургуулийн Зөвлөлд өгнө. Англи, Испани, Араб, Амхарик эсвэл Монгол хэлээр гаргаж болох тус тодорхойлолтын хуулбарыг Сургуулийн Зөвлөлд хүргүүлэх үедээ давхар сурагч болон/эсвэл түүний эцэг эх/асран хамгаалагчид хүргүүлнэ. Сурагч болон/эсвэл түүний эцэг эх/асран хамгаалагч нь Суперинтендент/хариуцагчийн шалтгааны тодорхойлолтыг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор Сургуулийн Зөвлөлд тухайн шалтгааны тодорхойлолтын хариуг өгч болно. Сургуулийн Зөвлөл нь шийдвэрээ бичгээр гаргах ба тус шийдвэр нь эцсийнх байна. Эцсийн шийдвэр гартал сургуулиас чөлөөлөхгүй эсвэл өөр хөтөлбөрт оруулахгүй.

СУРГУУЛИАС ХӨӨХ

Сургуулиас хөөх гэж Сургуулийн Зөвлөлийн журмын дагуу Сургуулийн Зөвлөлөөс гаргах аливаа арга хэмжээг хэлэх ба үүний хүрээнд сурагчийн гаргасан үйлдлийн ноцтой байдлаас шалтгаалан сурагчийг сургуульд суралцуулахгүй ба хөөсөн огнооноос хойш хуанлийн 365 дотор элсэх хүсэлт гаргах эрхгүй байна.

Авах гэж буй арга хэмжээ, түүний шалтгаан болон Сургуулийн Зөвлөлийн хуралд оруулах эрхийн талаарх мэдэгдлийг Англи, Испани, Араб, Амхарик эсвэл Монгол хэлээр бичгээр сурагч болон түүний эцэг эх/асран хамгаалагчид хүргүүлсэний дараа сурагчийг хөөж болно. Мэдэгдлийг Суперинтендент/хариуцагч өгөх ба нийтийн боловсрол сургалт, интервенцийн хөтөлбөрүүдтэй холбоотой мэдээллийг мөн олгоно. Сургуулийн Зөвлөлийн шийдвэр гарсан дараа сурагч болон түүний эцэг эх/асран хамгаалагчид тухайн сурагч сургуульдаа эргэн орж болох эсэх, сургуулиас хөөсөн хугацааны үед эсвэл дууссаны дараа Суперинтендент/хариуцагчийн зөвшөөрсөн боловсролын өөр хөтөлбөрт орох эсвэл сургуулийн системээс олгодог насанд хүрэгчдийн боловсролын хөтөлбөрт орох эсэх болон дахин элсэлтийн нөхцөлүүдийн талаар мэдэгдлийг хүргүүлнэ. Арлингтон Нийтийн Сургуулиудын зөвшөөрсөн хөтөлбөрөөс өөр хөтөлбөрт оруулах бол зардлыг эцэг эх/асран хамгаалагч хариуцна. Нэгээс дээш жилээр хөөгдсөн сурагчийн хувьд мэдэгдэлд тухайн сурагч нь хөөсөн огнооноос хойш хуанлийн нэг жилийн дараа дахин элсэх хүсэлтийг Сургуулийн Зөвлөлд гаргаж болох хийгээд дахин элсүүлэх аливаа нөхцөлүүдийг оруулсан байна.

Сургуулийн Зөвлөл нь сурагчийг хөөсөн хугацаа дууссаны дараа сурагчийг сургуульд эргүүлэн оруулж болно. Сургуулийн Зөвлөл нь Суперинтендентэд Арлингтон Нийтийн Сургуулиудад дахин элсүүлэх шийдвэр гаргах эрхийг өгнө. 365 хоногоос дээш хугацаагаар хөөгдсөн сурагч хөөх шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг жилийн дараа огнооноос өмнө ер (90) хүртэл хоногийн өмнө Суперинтендент/хариуцагчид дахин элсэх хүсэлт гаргаж болно. Суперинтендент/хариуцагч нь хуралдан хүлээн авсан мэдээлэл, сурагчийн өмнөөс олгосон бичгэн материал болон түүний хариуд ажилтны зүгээс олгосон нэмэлт материалуудад үндэслэн шийдвэр гаргана. Хуралд өгөх материал нь Сургуулийн Зөвлөлийн гишүүдээс өгсөн сургуулиас хөөх бичигт заасан бүх шаардлагыг хангаж байх ёстой. Суперинтендент/хариуцагч нь өргөдлийг ажлынхаа өрөөнд хүлээн авсанаас хойш 45 хоногийн дотор шийдвэр гаргана. Дахин элсэх хүсэлтийг Суперинтендент/хариуцагч татгалзсан тохиолдолд сурагч нь Сургуулийн Зөвлөлд бичгээр давж заалдаж болно. Дахин элсэх хүсэлт гаргах эрхийн мэдэгдэл болон нөхцөлүүдийг хөөх шийдвэртэй хамт дагалдуулж өгнө. Хөөх шийдвэр гаргасан өдрөөс хойш нэг жил тохиох өдрөөс дор хаяж 45 хоногийн өмнө шийдвэрээ гаргах боломжтой бол Сургуулийн Зөвлөл нь аливаа нөхцөл байдлыг цааш хэлэлцэн үзэж болно.

Галт зэвсэг, эвдлэн сүйтгэх багаж хэрэгсэл, мансууруулах бодис тараасан эсвэл хүний биед ноцтой гэмтэл учруулсан зэрэг зөрчил гаргасан сурагчид дээрх ажиллагааны дараа сургуулиас хөөх санал гаргана. Виржиниа Мужийн Код хууль 22.1-277.07-д заасанчлан хөөх саналыг дараах хүчин зүйлсийг бодолцон үзсэний дараа сургуулиас түр чөлөөлөх үндэслэлд заасан үйлдэл болон бусад үйлдлийн хариуд гаргаж болно.

1. Зөрчлийн шинж чанар, ноцтой байдал
2. Сургуулийн хамт олонд хэр аюултай эсэх
3. Сурагчийн Ёс Зүйн Журмын түүх, өмнө гаргаж байсан үйлдлүүдийн ноцтой байдал, тоо
4. Боловсролын өөр хөтөлбөрт оруулах боломжтой, зохистой эсэх
5. Сурагчийн нас, анги
6. Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэцэд нөлөөлөх бодисны буруу хэрэглээ, тусгай боловсролын үнэлгээний дүгнэлт
7. Сурагчийн ирц ба хичээл сурлага
8. Суперинтендент/хариуцагчийн зохистой гэж үзсэн бусад асуудлууд

АНС-Д СУРАЛЦУУЛАХААС ТАТГАЛЗАХ

Виржиниа эсвэл өөр мужийн сургуулийн зөвлөл эсвэл хувийн сургуулиас 30 хоногоос дээш хугацаагаар хөөгдсөн эсвэл чөлөөлөгдсөн эсвэл Виржиниа эсвэл өөр мужийн хувийн сургуульд элсэх хүсэлт нь татгалзагдсан сурагчийг сургуульдаа элсүүлэхгүй байх шийдвэрийг гаргаж болно. Тухайн сурагч нь хөөгдсөн, чөлөөлөгдсөн эсвэл татгалзагдсаны дараа Виржиниа эсвэл өөр мужийн сургуулийн өөр салбар нэгж, хувийн сургуульд элссэн байснаас үл хамааран тухайн сурагчийг элсүүлэхгүй байж болно. Тухайн сурагч нь Арлингтон Нийтийн Сургуулиудын бусад сурагч эсвэл ажилтнуудад аюул учруулсан болох нь тогтоогдсон бол Суперинтендент/хариуцагч нь дараах зүйлсийн дараа элсүүлэхгүй байх шийдвэрийг гаргаж болно:

1. Тухайн сурагчийг элсүүлэхгүй байх, түүний шалтгаан болон тухайн шийдвэрийн хуралд оролцож болох боломжийн талаарх мэдэгдлийг бичгээр сурагч болон эцэг эх/асран хамгаалагчид хүргүүлсэн
2. Тухайн хэргийн хурлыг Суперинтендент/хариуцагч хуралдуулсан.

Хурлын дараа Суперинтендент/хариуцагчийн шийдвэр гарсанаас хойш хуанлийн 15 хоногийн дотор Сургуулийн Зөвлөлийн Няравт давж заалдах хүсэлт гаргаагүй бол Суперинтендент/хариуцагчийн шийдвэр эцсийнх байна. (365 хоног болон түүнээс дээш хугацаагаар) элсэлтээс татгалзсан бол давж заалдалтыг хүлээн авсанаас хойш ажлын тав хоногийн дотор Суперинтендент/хариуцагч нь Сургуулийн Зөвлөлд элсүүлэхгүй байх саналын шалтгаан болон арга ажиллагааны бүртгэлийг Сургуулийн Зөвлөлд өгнө. Тус тодорхойлолтын хуулбарыг Сургуулийн Зөвлөлд хүргүүлэх үедээ давхар сурагч болон/эсвэл түүний эцэг эх/асран хамгаалагчид хүргүүлнэ. Сурагч нь Суперинтендент/хариуцагчийн шалтгааны тодорхойлолтыг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор Сургуулийн Зөвлөлд тухайн шалтгааны тодорхойлолтын хариуг өгч болно. Сургуулийн Зөвлөлийн Нярав нь Сургуулийн Зөвлөлийн хурлын огноог Суперинтендент/хариуцагч болон эцэг эх/асран хамгаалагчид мэдэгдэнэ. Тус хуралд мөрдөгдөх ажиллагааг Сургуулийн Зөвлөлийн Дарга Зөвлөлийн бусад гишүүдтэй зөвлөлдөн гаргана.

Давж заалдах хүсэлт гаргаж Суперинтендент/хариуцагч хариу өгсөний дараа Сургуулийн Зөвлөл нь элсүүлэхгүй байх эсэх дээр хэлэлцэн шийдвэрээ 45 хоногийн дотор сурагч болон эцэг эх/асран хамгаалагчид гаргаж өгнө.

ГОМДОЛ ГАРГАХ

Эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй эцэг эх эсвэл эрх бүхий сурагч орон нутгийн сургуулийн захиргааны ажилтан, Багш, Сурлагын Суперинтендентийн Туслах болон/эсвэл Захиргааны Үйлчилгээний Даргатай холбоо барьж болно. Мөн Арлингтон Нийтийн Сургуулиуд нь Гэр Бүлийн Боловсролын Эрх, Хувийн Нууцын Хууль (FERPA) эсвэл Сурагчийн Эрхийг Хамгаалах Нэмэлт Өөрчлөлтийн (PPRA) шаардлагуудыг мөрдөөгүй гэх гомдлыг эцэг эх, сурагч АНУ-н Боловсролын Хэлтэст дараах хаягаар гаргах эрхтэй:

Гэр Бүлийн Бодлого Мөрдөлтийн Алба

Family Policy Compliance Office

U.S. Department of Education 400
Maryland Avenue, SW Washington,
DC 20202-4605

Аливаа сурагчийг гарал угсаа, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, нас хүйс, эдийн засгийн байдал, бэлгийн чиг хандлага, гэрлэсэн байдал, жирэмслэлт, генийн мэдээлэл, жендерийн тодорхойлолт, илэрхийлэл болон/эсвэл хөгжлийн бэрхшээлээс үүдэн ямар нэг боловсролын хөтөлбөр, үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, тусгаарлах, тухайн хөтөлбөр, үйл ажиллагааны дор ялгаварлахыг хориглоно.

Хүйс болон бусад байдлаар ялгаварласан гэх гомдлыг даруй захиралд хүргүүлнэ. Үүнээс гадна хүйсээр ялгаварласан гэх гомдлыг Иргэний Эрхийн Боловсролын Албан Хэлтэс болон/эсвэл Захиргааны Үйлчилгээний Суперинтендентийн Туслах болох АНС-н IX Зэргийн Зохион байгуулагчид 703-228-6008 утсаар эсвэл administrative.services@apsva.us хаягт имэйл бичиж гаргах боломжтой.

Арлингтон Нийтийн Сургуулиуд нь сурагчдыг хичээл сурлага, нийгэм, бие сэтгэлээр онц сайн хөгжих боломжоор хангах сурагч бүрт тааруулсан материал бааз, үйлчилгээ, стратегиудыг олгох замаар өсөлт хөгжлийг дээд зэргээр бий болгох дэмжлэг үйлчилгээг олгохоор хичээж ажилладаг билээ. Зөвлөгч, нийгмийн ажилтан, сэтгэцэд нөлөөлөх бодисны буруу хэрэглээний зөвлөн туслагч нар нь сурагчийн сэтгэл зүйн сайн сайханд чиглэсэн мэргэжлийн дэмжлэг үзүүлдэг. Мөн сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйлчилгээний мэргэжилтэн болон дүүргийн материал баазууд байдаг.



Arlington
Public
Schools